**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**2022 он**

Цагааннуур сумын Засаг даргатй хамтран
ажиллах гэрээний хавсралт №1

**ТӨРИЙН ЗАХИРГАА, ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

2022.12.14 Хуурч

| Ажил, арга хэмжээ | | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| **1.1 Төрийн захиргааны ажил, арга хэмжээний хүрээнд:** | | | |
| 1.1.1 | Аймгийн " **Бүтээн байгуулалт- Нийгмийн хөгжлийг дэмжих жил**" –ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнах, үр дүнг тооцох | Сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын чиглэлийг баримтлан улсын хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, сумын төвийн замыг хатуу хучилттай болгох 6.2 тэрбум төгрөгийг батлуулан хэрэгжүүлж байна. Мөн аймгийн хөрөнгө оруулалтаар 370 сая, сумын хөрөнгө оруулалт, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1,3 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийсэн. | 100% |
| 1.1.2 | "**Үндэсний бичигтэн-2022-2024**" хөдөлгөөнийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх | "Үндэсний бичиг соёлын өдөр"-г тохиолдуулан Монгол үндэсний хэл бичгээрээ цэвэр сайхан бичих сурч эзэмших хүсэл эрмэлзлийг бадраах, хөхүүлэн дэмжих, бичих чадварыг нэмэгдүүлэх зорилготой "Сайхан бичигтэн", "цэвэр бичигтэн" шалгаруулах тэмцээн, төрийн албан хаагчид иргэдийн дунд шударга уншлагын тэмцээнийг зохион байгууллаа. Үүнд нийтдээ 106 гаруй иргэн, хүүхдүүд оролцон бүтээлийн үзэсгэлэнг гарган нийтэд үзүүлсэн.Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд: "Босоо Монгол бичиг минь" сургаал ,зүйр цэцэн үгсийн уран бичлэгийн уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангиллаар зохион байгуулан нийт 14 хүүхэд, 8 иргэн оролцсон. "Миний нутаг" шүлгийг монгол бичгээр хэн цэвэр сайхан бичих вэ" уралдааныг төсвийн байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулж, нийт 26 албан хаагч оролцсон. | 100% |
| 1.1.3 | Сумдын Засаг даргын Тамгын газар, тосгоны Захирагчийн албаны батлагдсан бүтэц орон тооны дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | Сумын ЗДТГ нь батлагдсан бүтэц орон тооны дагуу ажиллаж, ТЗ-ны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.4 | Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх E-mongolia системийг иргэд, олон нийтэд сурталчилж, төрийн үйлчилгээг цахимаар авах иргэдийн тоог нэмэгдүүлэх | E-mongolia цахим үйлчилгээний талаар сумын веб сайт болон цахим хаягаар дамжуулан сурталчилан ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар оператороор дамжуулан 154, гар утасны апплекейшнаар зөвлөгөө мэдээлэл, туслалцааг 184 иргэнд үзүүлсэн. | 100% |
| 1.1.5 | Сум, тосгоны албан ёснй цахим хуудасны байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх | Tsagaannuur.se.gov.mn албан ёсны цахим хуудсанд сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээлэл, санхүүгийн ил тод байдлын мэдээллийг тогтмол хугацаанд нь нийтлэн ажиллаж байна. | 100% |
| 1.1.6 | Иргэдийн өргөдөл, гомдлыг 1-10 хоногт багтаан шийдвэрлэж, хариуг тухай бүр албажуулан холбогдох байгууллага, иргэнд мэдэгдэж, “**Таныг сонсъё**” арга хэмжээг төр, төр төсвийн байгууллагуудад зохион байгуулах | 3 дугаар улирлын байдлаар сумын төр, төсвийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 42 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд 100% хувь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн.<br>2021 оны ажлын үр дүнг тайлагнах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 02 дугаар сард сумын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, ЭМТ-ийн ажилтнууд хамтран 8 хэсэг болж 1, 3 дугаар багийн 380 малчин өрхөөр явж өвөлжилт хаваржилтын байдалтай танилцан, сумын ЗДТГ-аас 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан болон цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажиллалаа.<br>Сумын Засаг дарга 1 дугаар улиралд 1, 2, 3 дугаар БИНХ-аар, 2 дугаар улиралд төр төсвийн байгууллагуудын албан хаагчидтай, 3 дугаар улиралд 2,3 дугаар багийн өдөрлөгөөр малчид иргэдтэй уулзалт зохион байгуулж ажиллалаа. | 100% |
| 1.1.7 | Монгол Улсын төрийн одон медаль, салбар, аймаг, орон нутгийн шагналд холбогдох журмын шаардлага хангасан иргэд, төрийн албан хаагчдыг тодорхойлж, баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллах | Монгол Улсын төрийн одон медаль, салбар, аймаг, орон нутгийн шагналд журмын шаардлага хангасан хүмүүсийг тодорхойлсон бөгөөд 2022 онд Төрийн дээд одон медаль “Монгол Улсын гавьяат механикжуулагч”-аар 1 иргэн, “Алтан гадас” одонгоор 6 иргэн, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар 3 иргэн, салбарын шагналаар 20 гаруй иргэн, орон нутгийн шагналаар 30 иргэн шагнагдсан. | 100% |
| 1.1.8 | Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох албан ёсны хэлцэл, санамж бичгийг батлуулахдаа дээд шатны байгууллага, албан тушаалтны удирдамжийн дагуу ажиллаж, гадаад арга хэмжээний тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх | Аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдамжийн дагуу Орос-Монголын аж үйлдвэрийн форумд сумын Засаг дарга төлөөлөгчөөр оролцсон. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.1.9 | Гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх | Оргих 1 дүгээр багийн нутаг Цацанд мал, амьтны гоц халдварт шүлхий /А01/ өвчний клиник шинж тэмдэг илэрч, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн шинжилгээгээр батлагдсан тул сумын Засаг даргын А/36 тоот захирамжаар голомтын бүсэд 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоож, Мал эмнэлгийн ерөнхий газраас хуваарилагдан ирсэн вакциныг сумын Засаг даргын А/40 тоот захирамжаар эрүүл, хамгаалалтын бүсэд дархлаажуулалтын 11 баг гарган ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Мөн дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэхээр 03 дугаар сарын 24-ний өдрөөс 6 сумын малын эмч, тархвар зүйч нар 5 хоног дайчлагдан ажилласан бөгөөд дархлаажуулалтыг сумын Мал эмнэлгийн нэгдлийн 4 малын эмч үргэлжлүүлэн хийж байна. Голомтын бүсэд 2 малын эмч 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 5-ны өдөр хүртэл ажиллаж өдөр бүр шинж тэмдгийн үзлэг тандалт хийх, айл хоорондын малыг нийлүүлэхгүй бэлчээхэд хяналт тавин, өвчний шинж тэмдэг илэрсэн өрхийн хашаа хороо, өвөлжөө, өтөг бууцын 8165 мкв талбайг уурын мананцаржуулагчаар халдваргүйтгэж малчдад зөвлөмж, зөвлөгөө өгч, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан. | 100% |
| **1.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд:** | | | |
| 1.2.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах | Төр , төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан болон бодлогын баримт бичгийн биелэлтийг улирал, жилээр авч нэгтгэн, аймгийн ЗДТГ, сумын ИТХ-д тайлагнан ажиллаж байна. | 100% |
| 1.2.2 | Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнд анхан шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах | МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж захирамж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээг тогтмол хийж ажиллаж байна. 2022 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газраас ажлын хэсэг ажиллаж сумын Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа, бодлогын бичиг баримтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт шалгалтын үр дүнгээр 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн Засаг даргын захирамжаар Цагааннуур сум нь Аймгийн “Тэргүүний сум”-аар шалгарсан.Мөн Сэлэнгэ аймаг дахь | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | төрийн аудитаас 2021 оны санхүүгийн гүйцэтгэлийн аудит, Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны төлөвлөгөөт хяналт шалгалт тус бүр 1 удаа, 2021, 2022 оны эхний хагас жилийн сумын дотоод хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн. | |
| 1.2.3 | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах ажлыг сумын төр, төсвийн байгууллагуудын хэмжээнд зохион байгуулах | Шилэн дансны нэгдсэн сайтад /shilendans.gov.mn/ мэдээллийг үнэн зөв бодитой тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэхийг байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт тухай бүр сануулж төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагуудад 1, 2, 3 дугаар улирлын хяналт шалгалтыг хийж гарсан алдаа дутагдлыг арилгах цаашид давтан гаргахгүй байх үүрэг чиглэл өгч ажилласан. 11 дүгээр сарын байдлаар ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 100% |
| 1.2.4 | Сумын төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөлвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, зөвлөгөө дэмжлэгээр хангах | Төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан болон бодлогын баримт бичгийн биелэлтийг улирал, жилээр авч нэгтгэн, аймгийн ЗДТГ, сумын ИТХ-д тайлагнан ажиллаж байна.<br>2022 онд Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитаас 2021 оны санхүүгийн гүйцэтгэлийн аудит, Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны төлөвлөгөөт хяналт шалгалт тус бүр 1 удаа, 2021, 2022 оны эхний хагас жилийн сумын дотоод хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн. | 100% |
| 1.2.5 | Төрийн байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, цаашид орон нутагт хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар 2-оос доошгүй удаа хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох | Төрийн үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, иргэдийн саналыг сумын төлөвлөгөөнд тусган ажиллах зорилгоор хагас, бүтэн жилээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг цахимаар болон цаасан хэлбэрээр авч ажиллалаа. Сумын төр төсвийн 7 байгууллага судалгаанд хамрагдсан. | 100% |
| 1.2.6 | Сум орон нутагт зохион байгуулах, зохион байгуулсан ажил арга хэмжээний мэдээг тухай бүр олон нийтэд мэдээлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн байгууллагуудад дамжуулан түгээх ажлыг тогтмолжуулах | 2022 онд суманд хийгдсэн бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээ, статистик тоо мэдээллийг улирал бүр нэгтгэн гаргадаг “Нуурын мэдээ” сонины 1, 2, 3-р улирлын хэвлэлт, 2021 оны сумын жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 02 дугаар сард 1000 ширхгийг хэвлэж иргэдэд тараасан.<br>Мөн цаг үеийн үйл явдлын мэдээллийг албан ёсны цахим хаягуудаар тогтмол мэдээллэж ажиллаж байна. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| 1 | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ТӨРИЙН ЗАХИРГАА, ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 15 | 15 | | | | | 100% |

Цагааннуур сумын Засаг даргатй хамтран
ажиллах гэрээний хавсралт №2

## ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| | Ажил, арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 2.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хууль, эрх зүй, хүний эрхийг хангах чиглэлийн зорилтууд, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж тайлагнах | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хууль, эрх зүй, хүний эрхийг хангах чиглэлийн зорилтууд, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 70% |
| 2.2 | “Шударга удирдагч, Шударга төрийн албан хаагч” аяныг үр дүнтэй өрнүүлж, Авлигатай тэмцэх үндэсний / УИХ-ын 2016 оны 51-р тогтоол/ болон Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх / АИТХТ-ын 2017 оны 105-р тогтоол/ аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээгрүүлэх ажлуудыг зохион байгуулах | Сэлэнгэ аймаг Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/292 дугаар захирамжаар батлагдсан “Шудрага удирдагч”, ”Шудрага төрийн албан хаагч” аян, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 17 албан тушаалтныг 02 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь гаргуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 2 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг зохих журмын дагуу хянуулж, хянасан дүгнэлтийг албан ёсны цахим хаягт олон нийтэд ил тод, нээлттэй байршуулсан.<br>Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан.<br>“Шударга –Удирдагч, Шударга –Төрийн албан хаагч” аяны хүрээнд СӨБ болон ЕБС-ийн эрхлэгч, арга зүйч нараар дамжуулан “Багшийн ёс зүй ухамсар сэтгэлгээг өөрчлөх” сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр багш туслах багш нарт зохион байгууллаа. Мөн “Байгууллагын соёл-эерэг хандлага” сэдвээр сургалт нийт ажилчдад зохион байгууллаа. | 70% |
| 2.3 | “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх 2020-2023 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, төр, төрийн бус, аж ахуй | Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх 2020-2023 оны арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган дотоод журмыг нийт албан хаагчдад | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | нэгж байгууллага дахь хүний эрхийн зөрчлийг бууруулах | танилцуулан, саналыг авч шинээр боловсруулсан. ЗДТГ-ын албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд байгуулсан./2.9/<br>Сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг 2022 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, 02 дугаар сарын 22, 23, 24-ний өдрүүдэд Оргих 1, Хуурч 2, Тийрэг 3 дугаар багийн иргэдийн Нийтийн Хурал хуралдаж багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны дарга сонгох, багийн Засаг даргад нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Сонгуулийн үйл ажиллагаанд хүний улс төрийн эрх, эрх чөлөө зөрчигдөөгүй. /4.23, 24/<br>Эмэгтэйчүүдийн өөрсдийн чадавхи оролцоогоо дээшлүүлж, өрхийн орлогоо нэмэгдүүлэхийг дэмжих зорилгоор соёлын төвийн үйл ажиллагаанд түшиглэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хүүхэд, иргэд болон эмэгтэйчүүдийн дунд “ПОЛИМОР” урлал болон “Нэхмэл гутал”-ын гар урлалын сургалтыг сургагч багштай нартай хамтран зохион явуулсан. Бэлэг дурсгалын зүйлс болон шүрэн эдлэлийн урлалыг эзэмшигч 4 иргэний бүтээлийн үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харахын зэрэгцээ өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилготой 1 иргэнд оёдол, эсгүүрийн үйл ажиллагааны чиглэлээр 5 сая төгрөг олгосон. /7.30, 31/<br>Малын үзлэг ангилалтыг явуулж Хангай, Баяд үүлдрийн хоньтой өрх, ААН-үүдийг нэг бүрчлэн хамруулж, ашиг шимийн дундажийг гарган, малчид, мал бүхий ААН-үүдэд үржлийн ажлын чиглэл, хээлтүүлэгчээр хангах ажлын талаар цаашид хамтран ажиллахаар тохиролцон Хангай үүлдрийн хоньтой 11 малчин, 2 ААН-ийн 800 хонинд 2023 оны 10 дугаар сард МУСҮТ-өөс гэрээгээр ашиглахаар авсан Алтай үүлдрийн хонь бүхий өрх, ААН-ийн 6 хуцаар зохиомол хээлтүүлэг хийсэн./8.37/<br>Хүрээлэн буй орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нэгдсэн хогийн цэгийг хашаажуулах, камержуулах ажлыг ОНХС-Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 168,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн.Мэргэжлийн хяналтын газраас 2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний дагуу хүнсний үйлдвэр худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй газруудад | |

| | | | |
|---|---|---|---|
| | | хүнсний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим сургалт хийсэн.Хүнсний бараа, түүхий эдийн аюулгүй байдлыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Нийт давхардсан тоогоор 22 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан./12.48/<br>Архины хамааралтай өрх толгойлсон 1 эмэгтэйг архины хамаарлаас гаргах эмчилгээнд явуулсан. Уг иргэнийг архины хамаарлаас гаргах, дуршил бууруулах, архины эсрэг үйлчилгээ үзүүлэх суулгацыг /Спираль/ суулгасан. Мөн 2 сарын хугацаатай 3 удаагийн давтамжтай уух дуршил бууруулах эмийг үйлчлүүлэгчид өгч, сар бүрийн хүнсний талонд хамруулсан. /12.49/<br>Иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлэгийн тусламж авах эрхийг хангах зорилгоор эмч эмнэлэгийн ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамруулж, суманд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэхээр ажилчдын байрыг барьж байна. Мөн алслагдсан багт хүрч үйлчлэх зорилгоор техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаан ажиллаж байна. /12.51, 52/ | |
| 2.4 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх / МУЗГ-ын 2018 оны 50-р тогтоол/ үндэсний болон Иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх /АИТХТ-ийн 2017 оны 154-р тогтоол/ аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Цахим эрх зүйн хөтөч” /www.e-khutuch.mn/ -ийн хэрэглээг нэмэгдүүлэн, хууль тогтоомжийн сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны 2022 оны ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах | Иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын хуулийг танилцуулах сургалт уулзалтыг 2 удаа зорилтот бүлгийн иргэдэд, 1, 2, 3-р багийн өдөрлөгөөр дамжуулан Газрын тухай хууль, Татварын тухай хуулиар 615 иргэнд мэдээлэл хийхийн зэрэгцээ Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д хүргэсэн. Мөн цахим орчноор дамжуулан Авлигын эсрэг хууль, гэр бүлийн тухай хууль, малын хулгайн тухай хуулиас 21 удаагийн нийтлэлээр танилцуулсан. | 100% |
| 2.5 | Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлж, зайлшгүй гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг гарган мөрдөж, захиргааны шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг тогтоон, сонсох | Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 онд сумын Засаг даргын 1 захирамж гаргахад сонсох ажиллагааг зохион байгуулж оролцогчдын оролцоог хангаан ажилласан. | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааг явуулж, иргэд, оролцогчдын оролцоог хангаж ажиллах | | |
| 2.6 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам / МУЗГ-ын 2020 оны 246-р тогтоол/ Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам / МУЗГ-ын 2021 оны 226-р тогтоол/-ыг хэрэгжүүлж, архивын өрөө, зориулалтын техник хэрэгслийг шийдвэрлэн, ББНШК-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, төр, төсвийн байгууллагуудын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж ажиллах | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, нийтлэг журмыг стандартын дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудсыг Тэнгэрбаатар ХХК-д захиалан хэвлүүлж улсын байцаагчаар хянуулан албан хэрэгцээнд ашиглаж байна.Мөн архивын өрөө, тасалгааг зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хანган ажиллаж байгаа.<br>БНШК-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, 2012 оноос хойш цахим хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан төр, төсвийн байгууллагуудын архивын баримтыг нягтлан шалгаж төрийн архивт шилжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 2.7 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх/АИТХТ-ийн 2017 ооны 96 дугаар тогтоол/ аймгийн хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг өмнөх оны мөн үеэс бууруулах | 2022 оны 10 дугаар сарын байдлаар 24 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд өмнөх оноос 41.2%-р өссөн байна. Үүнд хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 1, хүний эрүүл мэндэд хохирол учруулах 5, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 1, хулгайлах гэмт хэрэг 4, залилах гэмт хэрэг 5, мал хулгайлах авилгалын 1, хууль бусаар мод бэлтэгсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын 1, бусад 2 гэсэн гэмт хэргүүд бүртгэгдээд байна.2021 онд Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хулгайлах 1 гэмт хэрэг, байгаль орчны эсрэг зөрчил 4, гэмт хэрэг 6 бүртгэгдсэн. | 70% |
| 2.8 | Хүн худалдаалах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэн, хүүхэд эмэгтэйчүүд оролцсон гэмт хэргийн гаралтыг бууруулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг айл хөршийн холбоо, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах | Хөршийн холбоог сайжруулж хүчирхийлэлгүй сум болъё” сарын нөлөөллийн аяныг өрнүүлсэн. Аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийллийг мэдээллэх шуурхай утсууд болон сумын Хамтарсан багтай холбогдох шаардлагатай дугааруудыг иргэдэд сурталчлан таниулсан.<br>Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөлийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсуудыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна.<br>Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан.<br>Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сэдэвт сургалт, 6-11 дүгээр ангийн сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалт” сургалт, 6-12 дугаар ангийн хөвгүүдэд “Хорт зуршил” сургалтуудыг явуулж давхардсан тоогоор 812 эцэг эх, асран хамгаалагч, сурагчдыг хамруулсан. Мөн гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан . Сумын хамтарсан баг архины хамраалалтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн.<br>Хамтарсан багийн үүрэг чиглэлийн дагуу 2 дугаар цэцэрлэгийн багш зорилтот өрхийн хүүхдийн 1 удаа гэрээр эргэлт хийж, хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоо, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар яриа таниулгыг 72 эцэг эх, асран хамгаалагч нарт хийсэн. | |
| 2.9 | Хөдөлгөөний нягтрал ихтэй авто болон төмөр зам, гудамж, талбай, нийтийн орон сууцны гаднах талбайн камержуулалтыг нэмэгдүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг, хулгай, малын хулгай, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, согтуугаар үйлдэгдсэн зэрэг тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах | Гэмт хэрэг, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын төв зам дагуу 10 байршилд 16 камерыг шинээр байрлуулсан. Мөн гэрэлтүүлгийг сайжруулж сумын төвийн 154 гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг хийж бүрэн ашиглалтад оруулсан.<br>Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд нийт 200 гаруй малчин өрхөөр явж малын хулгайгаас болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл хийж гарын авлага тараалаа.<br>Цагдаагийн байгууллагаас Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа "Мал-Мах-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 1, 2, 3 дугаар багийн 113 малчин болон | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдын бүлэг нөхөрлөл байгуулах хэрхэн ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажилласан.<br>2021 онд Мал хулгайлах гэмт хэрэг 6 бүртгэгдэж байсан бол 2022 оны 11 дүгээр сарын байдлаар хулгайлах 1 гэмт хэрэг, байгаль орчны эсрэг зөрчил 4, гэмт хэрэг 6 бүртгэгдсэн. | |
| 2.10 | Суманд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хяналт тавьж, зөвшөөрөлгүй сүм хийдийг хуулийн этгээдийн бүртгэлд хамруулах, хамрагдаагүй сүм хийдийн үйл ажиллагааг таслан зогсоох | Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд бүртгэлтэй 2 сүм, хийд байна.Сүм хийдийн үйл ажиллагаанд сумын цагдаагийн алба ИТХ-аас байнгын хяналт тавин ажиллаж байна.<br>1. Нинж Долби хийд- н.Хатанбаатар.-зөвшөөрөлтэй<br>2. Амартайван сүм-С.Энхтайван-зөвшөөрөлтэй | 100% |
| 2.11 | Төр нийтийн ашиг сонирхол хөндөгдөж төрд хохирол учирсан тохиолдолд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан, Прокурорын газартай хамтран төрд учирсан хохирлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр Үнэгтэд 2022 оны 10 дугаар 16-ны өдөр бэлчээр 56 га, 10 дугаар сарын 23-ны өдөр 1 дүгээр багийн нутаг Цог-Өндөрт 256 га бэлчээр түймэрт өртөхөд 2 иргэн холбогдогчийг тогтоож түймрийн улмаас экологид учирсан хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх 6.637.684 төгрөг үүнээс 1.194.868 төгрөгийг хохирлыг барагдуулсан байна. Мөн холбогдогч 2 иргэнд зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авсан. | 100% |
| 2.12 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Өрсөлдөөний тухай, Зар сурталчилгааны тухай хууль, ШӨХТГ-аас зарласан жилийн хүрээнд тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцох | 2022 онд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын дагуу 6 аж ахуй нэгжийн зөвшөөрлийг сунгасан. Урьдчилан сэргийлэх 3 удаагийн хяналт шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуй нэгж хамрагдсан.<br>Суманд хүнсний бараа, түүхий эдийн аюулгүй байдлыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарч 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Нийт давхардсан тоогоор 22 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Шалгалтаар 74 нэр төрлийн /2сая 300мянга/ төгрөгний хүнсний бүтээгдэхүүн лангуунаас татуулан буцаалт хийлгүүлж, 120 гаруй нэр төрлийн /1 сая 970 мян/ төгрөгний хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтын журмын дагуу устгуулж ажилласан. Шалгалтаар 194 зөрчил илрүүлэн 180 буюу 92.7 хувийг арилгасан. Илэрсэн зөрчлийн 40 хувь нь шошгын мэдээллийг бүрэн тусгаагүй, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, гарал үүсэл нь тодорхойгүй, | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хадгалалтын горим алдагдсан, хугацаа дууссан зэрэг зөрчлүүд илэрч байна. | |
| 2.13 | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газар нутаг, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр хаягийг Монгол хэлээр хөтлөн явуулах, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг крилл болон үндэсний бичиг, англи хэлээр хослуулан бичих, Монгол Улсын стандарт MNS 5283:2014 тавих ерөнхий шаардлагыг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын албан тоотын дагуу суманд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн хаягийг үндэсний бичиг болон крилл бичгээр хослуулан бичиж байршуулах талаар албан бичиг хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. | 70% |
| 2.14 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг сурталчилж, МУ-ын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан “ Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам” –ын хэрэгжилтийг хангах | Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 1 ойн мэргэжлийн байгууллага 500.000 төгрөг, 3 н иргэн 650.000 төгрөг нийт 1.150.000 төгрөгийн торгуулийн 4 н шийдвэрийн хуудас бичигдэн сумын төрийн сангийн торгуулийн дансанд тушаасан. Мөн зөвшөөрөлгүй хууль бусаар мод бэлтгэсэн 6-н иргэнийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэн аймгийн цагдаагийн газарт шилжүүлсэн. | 100% |
| 2.15 | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, тогтоомж, аймгийн ИТХТ-ын 2021 оны 111 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/149 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, аймгийн Засаг даргаас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах | Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар гарын авлага, мэдээлэл бэлтгэн төрийн албан хаагч, иргэдэд сурталчлан ажилласан.<br>Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Гамшгаас хамгаалах тухай хууль, Ковид-19 болон бусад төрлийн хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 35 иргэн хамрагдсан.<br>Цас, зуд, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлгийг цахимаар болон алслагдсан багийн иргэдэд багийн Засаг дарга нар гар утас ашиглан шуурхай хүргэж байна.<br>Эрчим хүч, дулаан хангамжийн аюулгүй байдалд улирал бүр үзлэг хийж, шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн.Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай, нэг нь хашаалж хамгаалсан, 400 м3 багтаамжтай 1 усан сан, цэвэр усны 2,1 км урт шугам хоолой байдаг. Төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд 22 иргэн, 16 ААН | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | холбогдсон бусад айл өрхүүд 6 ус түгээх байр /худаг/-аас усаа авч байгаа бөгөөд бүгд хашиж хамгаалагдсан байна. Төвлөрсөн системээс улирлын чанартай татсан цэвэр усны шугамд 75 өрх холбогддог. Мөн сумын төвд иргэдийн энгийн уурхайн 90 худаг байна.<br>Сүүлийн жилүүдэд иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлж 1,7 км хатуу хучилттай зам, 4,5 км сайжруулсан зам дагуу 140 ш гэрэлтүүлэг, камержуулалтыг 5 цэгт хийсэн.<br>Шинээр 150 хүүхдийн цэцэрлэг ашиглалтад оруулснаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт сайжирсан.<br>Тохижилт ногоон байгууламж бий болгох хүрээнд “Ногоон сум” , “Мянган нарс” хөтөлбөрүүд сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж одоогоор 750 нарс 400 бусад мод, бут, сөөг тариад байна. Мөн хүүхдийн тоглоомын талбай тохижуулж спортын задгай талбай бий болгож байна.<br>"Ардын хувьсгалын 100 жил", "Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90-н жил"-ийн ой, "Тохижилт-ногоон байгууламж аян", Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн санаачилсан "Ногоон сум" арга хэмжээний хүрээнд сумын төвийн хатуу хучилттай замын дагуу 250 мод тарьж хашаажуулсан.<br>Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай, нэг нь хашаалж хамгаалсан, 400 м3 багтаамжтай 1 усан сан, цэвэр усны 2,1 км урт шугам хоолой байдаг. Төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд 22 иргэн, 16 ААН холбогдсон бусад айл өрхүүд 6 ус түгээх байр /худаг/-аас усаа авч байгаа бөгөөд бүгд хашиж хамгаалагдсан байна. Төвлөрсөн системээс улирлын чанартай татсан цэвэр усны шугамд 75 өрх холбогддог. Мөн сумын төвд иргэдийн энгийн уурхайн 90 худаг байна.<br>Цагааннуур суманд 2 дугаар багийн эх үүсвэрийн гүний цагаан худаг, энгийн 2 худаг, гүний 2, 3 багт энгийн 2 худаг, хонхорт 1, нийт суманд 6 худаг ажиллаж байна.<br>Мэргэжлийн хяналтын газар 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр гүний эх үүсвэр, гэр хорооллын гүний худаг, 2 дугаар цэцэрлэгийн гал тогоо, эрүүл мэндийн төвийн гал тогоо, 1 дүгээр цэцэрлэгийн гал тогоо, сургуулийн гал тогоо зэргээс дээж авч аймгийн мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид | |

| | | | |
|---|---|---|---|
| | | шинжилгээнд хамруулсан.<br>Шинжилгээний дүн: Гүний эх үүсвэр нь Ундны ус Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын MNS 0900:2018 стандартын бичил амь судлалын шинжилгээний үзүүлэлт, ундны усны байгалийн гаралтай химийн үзүүлэлтээс фтороос бусад үзүүлэлт стандартын шаардлага хангаж байна. | |
| 2.16 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, бүртгэл судалгааг хуулийн дагуу явуулан тайлан мэдээг аймгийн ЗДТГ-т сар бүр мэдээлж тайлагнах | Шаамар-Түшиг чиглэлийн хатуу хучилттай зам тавьж байгаа Монгол ЛЗ зам гүүр ХХК-нд үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын иргэдийн бүртгэл судалгааг Цагдаагийн албатай хамтран тогтмол хийж холбогддох газарт хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 16 | 11 | 5 | | | | 90.6 % |

Цагааннуур сумын Засаг даргатй хамтран
ажиллах гэрээний хавсралт №3

## ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Ажил арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 3.1 | Мал аж ахуйн 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах | Сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын А/107 тоот захирамжаар "2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, өвөлжилтийг хохиролгүй даван туулах ажлын хэсгийг байгуулж төлөвлөгөөг боловсруулан өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллаж байна. | 100% |
| 3.2 | Малын тоо толгойн албан татварын орлогоос мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх | Сумын ОНХС-Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 178,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр Оргих 1 дүгээр багийн Гэр чулууны давааг бүрэн засварласан. Мөн бэлчээрийн бохирдлыг хамгийн ихээр үүсгээд байсан сумын нэгдсэн хогийн цэгийг хашаажуулах, камержуулах ажлыг ОНХС-Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 168,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 3.3 | Тариалангийн бүс нутагт үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлагаг хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулах | Газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах, эзэмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын 1-р багцад хамрагдсан Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдад "Хуурч сүрэг" хоршооны ангилалт, үзлэгийн баг шинжээч мал зүйч 1, ангилагч мал зүйч 2, бүртгэлийн ажилтан 2, мал баригч 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг доорх үе шаттайгаар үзлэг ангилалтыг явуулсан.<br>06 дугаар сарын 02-ноос 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нийт сүргийн ангилалт, үзлэг, хэмжилтүүдийг явуулж, ялган тэмдэглэгээ хийн, бүртгэлийг хөтлөн, программд шивэх, 06 дугаар сарын 15-наас 07 дугаар сарын 10–ны өдөр хүртэл ангилалтад хамрагдсан хонин сүргийн ноосны гарцыг тодорхойлох хяналтын хяргалт, амьдын жингийн өөрчлөлтийг тодорхойлох, 07дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл үхэр, хонин сүргийн намрын амьдын жин, үндсэн хэмжээсүүдийн өөрчлөлт, эзэмэгжүүлэлт, бүртгэл хийх гэсэн үе | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | шаттайгаар ажилласан. Үзлэг ангилалтад зайлшгүй хамрагдах ёстой Хангай, Баяд үүлдрийн хоньтой өрх, ААН-үүдийг нэ гбүрчлэн хамруулж, ашиг шимийн дунджийг гарган, малчид, мал бүхий ААН-үүдэд үржлийн ажлын чиглэл, хээлтүүлэгчээр хангах ажлын талаар цаашид хамтран ажиллахаар тохиролцон Хангай үүлдрийн хоньтой 11 малчин, 2 ААН-ийн 800 хонинд 2023 оны 10 дугаар сард МУСҮТ-өөс гэрээгээр ашиглахаар авсан Алтай үүлдрийн хонь бүхий өрх, ААН-ийн 6 хуцаар зохиомол хээлтүүлэг хийсэн.<br>Үйл ажлллагааны хүрээнд Цагааннуур сумын 62 өрх, 2 ААН-ийн нийт 12012 малд, Зүүнбүрэн сумын 36 өрхийн нийт 7533 малд, Түшиг сумын 18 өрхийн нийт 3978 малд, нийтдээ 23523 малд үзлэг хийж, 23246 малын үндсэн үзүүлэлтүүд болох сэрвээ, хондлойн өндөр, биеийн ташуу урт, шилбэний бүслүүр, бүсэлхийн тойрог, цээжний гүн, өргөн, амьдын жингийн хэмжээг авч, ялган тэмдэглэгээ хийн, “Мал аж ахуйн нэгдсэн систем”-д шивэн баталгаажуулсан. | |
| 3.4 | Эрчимжсэн мал аж ахуй, фермерүүдийг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилан баталгаажуулах | Газар тариалангийн бүсэд үржүүлж буй малд үзлэг ангилалт явуулах ажлын хүрээнд мал сүрэг нь сүргийн бүтэц, үүлдэрлэг байдал, ашиг шимийн үзүүлэлт хангасан 17 малчин, 1 ААН-д гэрчилгээ олгуулахаар аймгийн ХХААГ-т уламжилсан . | 30% |
| 3.5 | Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, дэмжин ажиллах | Суманд “Хуурч сүрэг” мал үржлийн нэгж, үржил технологийн үйл ажиллагааг эрхэлж байна. | 70% |
| 3.6 | Бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг технологийн ажлыг ажил, үйлчилгээний нэгжид төвлөрүүлэх | Малын удмын сангийн үржлийн төвөөс “Алтай” үүлдрийн нарийн ноост 2 хуц авч, “Хангай” үүлдрийн хонины зохиомол хээлтүүлэгт ашиглаж байна. | 100% |
| 3.7 | Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах | Сумаас гарч буй мал, малын гаралтай түүхий эд, махны мал эмнэлэгийн гэрчилгээнд хяналт тавьж , Мал эмнэлэгийн нэгдсэн системд шивж баталгаажуулж байна. 2022 онд сумаас амьд мал, амьтан 10917 толгой, мах 297767кг, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн цувдай 19872кг, толгой 3181ш, аарц 85кг, ааруул 52кг, шар тос 10кг, өрөм 10кг, арьс шир 2856ш тус тус 2085 ширхэг гарсан байна. | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.8 | Малын ашиг шимийг нэмэгдүүлхэд шинжлэх ухааны ололт дэвшилтэд Биотехнологийн /зохиомол хээлтүүлэг/ арга технологийг ашиглах, сурталчлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах | Малын удмын сангийн үндэсний төвтэй байгуулсан гэрээний дагуу мал үржлийн "Хуурч сүрэг хоршоо 424 үнээнд хээлийн шалгалт хийж, 306 үнээнд ороо идэвхжүүлэгч ашиглан ороог жигдрүүлэн мах, сүүмахны Лимүзин, Герфорд, Ангус, Сементаль, Монблиард үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн. | 100% |
| 3.9 | Арьс шир хуулах төхөөрөмжийг мал төхөөрөх цехэд нэвтрүүлэх | Хэрэгжээгүй | 0% |
| 03.10 | Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг технологит хугацаанд шуурхай зохион байгуулах | Сумын Засаг даргын “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгжуулах тухай” А/75 тоот захирамжийн дагуу гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг техинологит хугацаанд чанартай зохион байгуулж ажилласан.<br>Суманд үйл ажиллагаа явуулж буй 4 мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд бод, богийн боом, үхэр, нохойн галзуу, гахайн мялзан, үхэрт цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 1,2 дугаар тун вакцин, дуут хавдар, тугалын иж балнад, ГЦХИБ, адууны томуу, шөвөг яр, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад төлөвлөгөөний дагуу 100% хийж гүйцэтгэн мал эмнэлгийн цахим системд төлөвлөгөө, гүйцэтгэл 100% оруулж, санхүүжилтийн материалтай нэг бүрчлэн тулган баталгаажуулсан.<br>Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад нийт 48200 толгой хурга, ишиг, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт 13800 толгой бод, 22800 толгой бог,<br>дуут хавдар нийт 8800 толгой үхэр, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 3800 толгой бод, 600 нохой,гахайн сонгомол мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт 2100 гахай, ГЦХИБ өвчнөөс сэргийлэх тарилгад нийт 1500 гахай, хамруулж, тугалын иж балнад өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1065 толгой тугал, цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 5400 толгой үхэр, адууны томуугын тарилгад 1600 толгой адуу, Сахуу өвчнөөс сэргийлэх тарилгад 1600 толгой адууг төлөвлөгөөний дагуу бүрэн хамруулж вакцинжуулалтыг 100 хувь гүйцэтгэн мал эмнэлгийн цахим системд оруулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт угаалга, туулгалт, боловсруулалтыг технологит хугацаанд 100% хийж гүйцэтгэсэн. | |
| 3.11 | Мал, амьтны гэрчилгээ, баталгаажуулалтын нэгдсэн цахим системийн хэрэгжилтийг бүрэн нэвтрүүлэх | Мал эмнэлгийн нэгдсэн системд мал амьтны гэрчилгээнд хяналт тавин баталгаажуулалт хийж ажиллаж байна. | 100% |
| 3.12 | “Атар IV” аяныг өрнүүлэн, тариалангийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх | Атар IV аяны хүрээнд сумын хэмжээнд нийт 53029 га эргэлтийн талбайгаа 100% амшиглан тариалан эрхэлж байна. 2022 онд 38864 га талбайд үр тариа, тэжээлийн ургамал, тосны ургамал, төмс, хүнсний ногоо тариалсан. | 100% |
| 3.13 | Тариалангийн талбайг хашаажуулах, хамгаалалтын агро ойжуулалтын ажлыг зохион байгуулах | Тариалангийн талбайг хашсан хашааг тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй ААН, иргэдэд хуваарилах ажлыг зохион байгуулж дуусгасан. Нийт 150 км хашааг 39 иргэн, ААН-д хуваарилахаар болж 12 сард эзэмшүүлэх гэрээнд гарын үсэг зуруулахаар бэлэн болоод байна. | 50% |
| 3.14 | Ургамал хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт организмийг устгах, Ургамал хамгааллын бодис бордооны зохистой хэрэглээ төлөвшүүлэх хяналт тавьж ажиллах | Тариалан эрхэлж буй ААН, иргэдийн эзэмшиж буй тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор бордоотой тариалан эрхлэлтэд анхаарч ажиллалаа. 2022 онд суманд газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй ААН, иргэд Эдагум 2,8 тонн, гумат 2,54 тонн, белый жемчук – 2,68 тонн, адью -1,29 тонн –ыг тариалалтадаа хэрэглэж га-н дундаж ургац 15,5 цн буюу өмнөх онтой харьцуулхад 1,5 цн-р өссөн байна. | 100% |
| 3.15 | Хүнсий ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг сум бүрт 20 га-аар нэмэгдүүлэн шинээр газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах | Сумын хэмжээнд төмс, хүсний ногоо тариалах боломжтой газрыг нэмэгдүүлж 10 га газрыг шинээр олгохоор шийдвэрлээд байна. | 30% |
| 3.16 | “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлхэд онцгой анхаарч тариалалтыг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлж, 10 га талбай агро ойн аж ахуй байгуулах, жимсний суулгацны палантаци байгуулахыг дэмжиж ажилллах | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5,10 дугаар сард “ТЭРБУМ МОД-ЦАГААННУУР СУМ 2022” зөвлөгөөнийг сум дундын ойн ангитай хамтран зохион байгуулж Шаамар сумын мод үржүүлгийн газруудтай хамтран тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод 21 ширхэг, жимсний мод 69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод 82 ширхэг, жимсний мод 184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 258 ширхэг, гоёлын мод | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 463 ширхэг, жимсний мод 253 буюу нийт 974 ширхгийг тарьсан. | |
| 9.8 | “Монгол бичиг үндэсний хөтөлбөр-III”-г хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон хувийн байгууллагын албан хаагчдад монгол хэл бичгийн хичээл заах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш нарт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | 2022 оны 4, 5 дугаар сард сумын Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын багш хамтран байгууллагын нийт 31 багш ажиллагсдад Монгол бичгийн 40 цагийн сургалтыг зохион байгуулан багш, ажилчид монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн “Монгол бахархал”-ын өдрийг тохиолдуулан “Хичээнгүй бичицгээе” бичгийн уралдаан хамт олныхоо дунд зохион байгуулан явуулсан.<br>Үндэсний Монгол бичгийн 1 сарын сургалтад 22 багш, ажилтан хамрагдаж анхан шатны сургалтын батламжаа авсан. Багш ажилчид өөрсдөө бие даан суралцаж Монгол бичгийн групп чат /дасгал даалгавар авах, хийснээ шалгуулах зэргээр/ нээн ажиллаж байна. Эрхлэгчийн болон багш, арга зүйчийн хөтлөх нэрийн баримт бичгийг Монгол бичгээр хаягжуулсан байна. | 70% |
| 9.9 | Сургуулийн гал тогоог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах, сайжруулах, засвар үйлчилгээ хийх. | Гал тогоо иж бүрэн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан | 100% |
| 9.10 | Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болох | Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар бохир соруулах автомашинтай болсон.<br>Цэцэрлэгийн бүлэг тус бүрт хүүхдийн зориулалттай стандарт шаардлагын дагуу анги бүлэг бүрт 3 ш гар угаалтуур, 2 ш суултуур, 1ш шээлтүүртэй. Суултуур тус бүр зөөлөвчтэй бөгөөд тус бүрийн хооронд стандартад заасны дагуу хоорондоо тусгаарлах таславчтай. Ариун цэврийн өрөө бүрт хүүхэд халтирч гулгахаас сэргийлсэн шалавчийг байрлуулсан. Мөн анги бүлэг бүрийн ариун цэврийн өрөөнд хүүхэд усанд орох боломжийг бүрдүүлж бойлуур суурилуулсан.<br>Хичээлийн А байрны охидын ариун цэврийн өрөөг дунд болон | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ахлах ангийн багш, сурагчдын санаачлагаар суманд үйл ажиллагаа явуулдаг 2 дэлгүүрийн хандив дэмжлэгээр тохижуулсан. Үүнд охидын ариун цэвэрч байдлыг хангах зорилгоор ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг тогтмол байршуулан хэрэглүүлж байна. | |
| 9.11 | Шаардлагатай 1-2 кабинетийг иж бүрэн тохижуулж, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангахад хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх | 1 дүгээр цэцэрлэгийн хамт олны санаачлага, дэмжлэгээр нэг ангийн орны өрөөг шинээр тохижуулж хүүхэд өөрөө үйлийн эзэн нь байх, тоглонгоо чадвар эзэмших, өөрөө өөртөө үйлчлэх хөдөлмөрт сургах “БИ ӨӨРӨӨ”өргөөг шинээр бүтээн байгуулсан.“БИ ӨӨРӨӨ” өргөөнд хүүхдүүд сонголтын булангийн цагаараа орж багшийн дэмжлэг тусламжтай хоол хийх, өндөг чанах шарах, ногоо арилгах, салат, зууш бэлтгэх энгийн чадварт суралцах, аяга тавгаа хурааж угааж, арчих, өөрсдийн хамрын алчуураа угаах, индүүдэх, хүүхэлдэйн оймсыг угаах, энгийн оёдол эсгүүр хийх, мужааны хөдөлмөрт суралцах зэрэг өөрөө өөртөө үйлчлэх хөдөлмөрт суралцаж байна.<br>БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, Сэлэнгэ аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд багш, сурагчдын мэдээллийн технологийн чадавхийг нэмэгдүүлэх зорилготойгоор мэдээлэл зүйн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий тохилог анги танхимаар хангагдсан.<br>Уг зорилтын хүрээнд сумын Засаг дарга, ЗДТГ-аас 1, 2 дугаар цэцэрлэгт А3 өнгөт принтер, ЕБС-д 4ш А4 принтер олгосон. | 100% |
| 9.12 | Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд орон нутгийн тохирлын баталгаанд хамрагдсан хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг нийлүүлэх, сургуулийг түшиглэн туслах аж ахуй хөгжүүлэх | Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг хууль дүрмийн дагуу тендер зарлаж зөвшөөрөгдсөн аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсны үндсэн дээр баталгаатай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байна. 2021 онд шинээр цэцэрлэгийн хүүхдийн туршилт танин мэдэхүйн үйл ажиллагаанд зориулсан 400мкв бүхий “Туршилтын талбай”-г эцэг эх багш ажиллагчдын санаачлага дэмжлэгээр байгуулж 10 гаруй нэр төрлийн хүнсний ногоо тариалж 140кг төмс, 85 кг өргөст хэмх, 40кг улаан лооль, 35кг сонгино, 5кг саримс, 50кг байцаа ,25кг манжин, 28кг лууван, 20кг улаан манжин, 10 кг чинжүү хураан авч хүүхдийн хүнсэнд хэрэглэж байна.<br>ЕБС болон СӨБ-ын үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтэд дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, шинэ, чанартай бүтээгдэхүүнээр хангах зорилгоор суманд үйлдвэрлэл явуулдаг “Уранцацал” ХХК, | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | “Ноён Уулын хишиг” ХХК, “Шүрэн тариа” ХХК-аас сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, 2 хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэнээс ногоо худалдан хүнсэнд хэрэглэж байна. | |
| 9.13 | Хүүхдийн байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих | “Эрүүл хүнс–Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд СӨБ-ын байгууллагууд хүүхдийн хоол хүнсний нэр төрлийг олшруулах, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдийн хоолонд хэрэглэх зорилгоор хүлэмжид өргөст хэмх, улаан лооль, амтат чинжүү тарьж хэрэглэж байна. Мөн өдөрт 1-2 удаа байгалийн гаралтай жимс, жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүнээр хангаж хяналт тавин ажиллаж байна. Ундны усны дээжийг жилд 2 удаа мэргэжлийн хяналтын эрүүл ахуйн лабораторид өгч шинжлүүлэн, мах сүү, хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн шинжилгээний бичгийг харгалзан татан авалт хийж байна.<br>Мөн цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйг сайтар сахиж, тогтмол цэвэрлэгээ үйлчилгээ хийхээс гадна хоолны дээжийг тогтмол авч 72 цагийн дотор хадгалан хяналт тавин устгал хийж түүнийгээ цаг тухайд нь тэмдэглэж байна.<br>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартад тусгагдсанаар хүүхдийн хоолны хэрэглэлийг бүлэгт байрлуулахгүйгээр гал тогооны хэсэгт зааврын дагуу угааж халдваргүйжүүлэн, дахин бохирдохгүй нөхцөлд хадгална /MNS 6558:2015/ 5.6.2 гэсэн заалтыг мөрдөж ажиллаж байна. Үүний үр дүнд цэцэрлэгийн хоол хүнсний хэрэгсэл, сав суулгын хадгалалт, ариун цэврийн шаардлага тодорхой түвшинд хангагдаж байна.<br>Энэ хичээлийн жилд БШУЯ-аас ирсэн чиглэл, удирдамжийн дагуу хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх давс, элсэн чихрийн хэмжээг багасгах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, эцэг эхчүүдэд заавар зөвлөгөө өгч ажиллахын зэрэгцээ хүүхдийн хоол хүнсэнд хяналт тавьж ажиллаж байна.<br>Мөн эрхлэгч, нярав, тогооч нар дараах асуудалд тогтмол анхаарал хандуулж байна.<br>• Түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын гэрчилгээ, шинжилгээний дүнд үндэслэх<br>• Хоол хүнсэнд шошгын шаардлага хангасан хүнс, эрүүл ахуйн шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр хүүхдийн хоол хүнсийг хийх | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | • Бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийг зориулалтын хөргөх төхөөрөмжид хугацааг тэмдэглэн хадгалах<br>• Гүн хөлдөөж, хөргөөж хадгалах хүнс, түүхий эдийн хугацааг тэмдэглэн шошгожуулан, түрүүлж орсныг эхэлж гаргах зарчмыг баримтлах<br>• Хоолны жор, технологийн картад орц, илчлэг, шим тэжээллэг чанар боловсруулах технологи ажиллагааг тусган өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах<br>• Дотоод хяналтын багийн ажилтны чиг үүрэгт давхар тусган үүрэгжүүлэн дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг шалгаж тухай бүр биелэлтийг тооцох<br>• Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн ул мөрийг мөрдөн тогтоох “ Урагшаа нэг шат”, “Хойш нэг шат” бүртгэлийг хөтлөх<br>• Хүнс түүхий эдийг буцаан таталт хийсэн бүртгэлийг тухай бүрд хөтлөн тэмдэглэл хийн ажиллаж байна. | |
| 9.14 | Насан туршийн боловсролын төв болон бусад байгууллагаас зохион байгуулж буй амьдрах ухаан, эрүүл мэнд, эрх зүй, ёс суртахуун, мэдээллийн технологи, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад иргэдийг хамруулах | Соёлын төвийн үйл ажиллагаанд түшиглэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хүүхэд, иргэд болон эмэгтэйчүүдийн дунд “ПОЛИМОР” урлал болон “Нэхмэл гутал”-ын гар урлалын сургалтыг сургагч багштай нартай хамтран зохион явуулсан. Бэлэг дурсгалын зүйлс болон шүрэн эдлэлийн урлалыг эзэмшигч 4 иргэний бүтээлийн үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулсан. Мөн иргэдийн “Дунд соёлын бүтээлч үйлдвэрлэл” уралдаан зарлаж нийт 6 иргэний бүтээлийн олон нийтэд танилцуулан урамшуулсан.<br>Мэргэжлийн чиг баримжаа олгох талаар 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 5 багш, 82 сурагчийг хамруулсан. Ахлах ангийн АУБ нар ангийн сурагчиддаа “Мэргэжлийн үнэ цэнэ”, “Мэргэжил сонгохын учир”, “Мэргэжил гэж юу бэ” сэдэвт сургалт хичээл, зөвлөгөөг өгч ажилласан ба давхардсан тоогоор 172 сурагчийг хамруулсан.<br>Иргэдийн эрх зүйн чадамжийг дээшлүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын хуулийг танилцуулах сургалт уулзалтыг 2 удаа зорилтот бүлгийн иргэдэд, 1, 2, 3-р багийн өдөрлөгөөр дамжуулан Газрын тухай хууль, Татварын тухай хуулиар 615 | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| | | иргэнд мэдээлэл хийхийн зэрэгцээ Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д хүргэсэн. Мөн цахим орчноор дамжуулан Авлигын эсрэг хууль, гэр бүлийн тухай хууль, малын хулгайн тухай хуулиас 21 удаагийн нийтлэлээр танилцуулсан | |
| 9.15 | "Оюутан танд тусалъя" цар тахлын үед оюутнуудыг хичээл сургалт болон сургалтын төлбөр, ажлын байрны талаарх мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах | Сумын ЗДТГ, болон ЕБС, 1, 2 дугаар цэцэрлэг, ЭМТөв зэрэг байгууллагуудад ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд байгууллагын болон сумын ввэб сайт, цахим хуудсаар мэдээлж ажилласан. Төсвийн байгууллагуудад шинээр сургууль төгссөн оюутнуудаас 6 иргэн шинээр ажлын байртай болсон. | 100% |
| 9.16 | Сургууль бүр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | ЕБС-д сэтгэл зүйчийн орон тоог батлуулан Сэтгэл зүйчтэй болсон. | 100% |
| 9.17 | "Хөдөлмөр амралтын зуслан" байгуулах ажлыг эхлүүлж сургууль, цэцэрлэгүүдэд аж ахуй эрхлэх боломжийг бүрдүүлэх | 2 дугаар цэцэрлэгийн гадна талбайн тохижолтод хүүхдийн туршилтын 300 мкв талбайг сунган стандартын дагуу хашаажуулж, бага насны хүүхдийг хөдөлмөрийн энгийн дадалд сургах, туршилт танин мэдэхүйн талбай буюу сургалтын гадаад орчинд хүүхэд бие даан үйлд оролцох боломж нөхцөлийг бүрдүүлж хэрэглэгдэхүүнийг хийж байршуулсан. Туршилтын талбайн замыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан цементэн замыг хийн ажиллахаас гадна бүлэг тус бүр 18 мкв бүхий нийт 108 мкв туршилтын талбайг хийж тухайн туршилтын талбайд 8 нэр төрлийн хүнсний ногоог тарьсан. 64 мкв бүхий 2 ш хүлэмжнээс нийт 500 гаруй кг хүнсний ногоо хураан авч хүнсэндээ хэрэглэсэн. | 50% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 17 | 13 | 3 | 1 | | | 92 % |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсраль №10

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

| № | Ажил, арга хэмжээ | Биелэлт | хувь |
|---|---|---|---|
| 10.1 | Сум орон нутагтаа нийтийн биеийн тамир , спортыг иргэдийн эрүүл мэнд ,идэвхтэй амьдралын хэв маяг , аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлэх | Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн оролцоог сайжруулах, суманд олон төрөлт спортыг хөгжүүлэх зорилгоор 3 дугаар сард сумын аварга шалгаруулах волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн, 10-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 3 төрлөөр, Аймгийн ахмадын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 4 төрлөөр, Багш нарын баярын өдөрт зориулан волейболын тэмцээн, 11 дүгээр сард Хөдөө аж ахуйд ажиллагсадын баярын өдөр, Монгол Улсын арслан Б.Орхонбаярт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүрээнд Волейболын тэмцээн тус тус зохион байгуулж нийт давхардсан тоогоор 520 орчим иргэн хамрагдаж оролцсон байна. Иргэдийн 80 хувийг нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамруулсан байна.Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилга,Биеийн тамир,спортын улсын хорооноос зохион байгуулж буй “ Илүүдэл жингүй –Эртэч Монгол ” аян зарлагдаж суманд давхардсан тоогоор 1756 иргэд хамрагдсан. Мөн 11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 15-ны хооронд Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан “Жингийн илүүдэлгүй-Эртэч Сэлэнгэчүүд”” аяныг зохион явуулсан. | 100% |
| 10.2. | Биеийн тамир ,спортын үйл ажиллагааг хариуцсан орон тооны арга зүйчтэй болох | Сул орон тоон дээр мэргэжлийн арга зүйч авч ажиллуулж байна. | 100% |
| 10.3. | Хүн амд” Нийтийн биеийн тамир , спорт” –ын үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан хамтын ажиллагааг өргөжүүлэх | *Илүүдэл -Жингүй –Эртэч* Монголчууд аяны хүрээнд 12 төрийнболон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна. 06 -70 насны иргэд 1756 оролцлоо. Иргэд өглөө бүр алхалт хийх, ахмадууд ахмадын байрандаа иогоор тогтмол хичээллэх, залуучууд унадаг дугуйгаар хичээллэж хэвшээд байна. | 100% |
| 10.4 | Олон улс , тив дэлхийн болон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох багш дасгалжуулагч , тамирчдыг бодлогоор дэмжин ажиллах | Сэлэнгэ аймгийн “Нарт “ сумо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нийт 7 тамирчинд дэмжлэг үзүүлэн оролцуулсан ба тамирчид амжилттай оролцож алт, хүрэл медаль хүртлээ. Бүх ард түмний XV спортын их наадамд 2 тамирчин сум орноо төлөөлөн | 30% |

| | | | |
|---|---|---|---|
| | | оролцон, улсад ПАРАЖУДО-ын эмэгтэй 48 кг-ийн жинд Алтан медаль, эрэгтэй 100, 200 метрийн гүйлтийн тэмцээнд Хос алтан медаль хүртсэн Тамирчдыг сумын Засаг дарга баяр хүргэн шагнаж урамшуулсан. | |
| 10.5 | Спорт цогцолборын орчин нөхцөлийг сайжруулж байнгын үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр тасралтгүй хангах | Спорт цогцолборын их засварын ажил хийгдэж хүлээлгэн өгсөн. Уг ажлаар бэлтгэлийн өрөө, фитнес, үүдний танхим, бие засах өрөө, албан хаагчдын өрөө, теннисний танхим зэргийг бүрэн засварлаж орчин нөхцөлийг сайжруулсан. | 100% |
| 10.6 | Спорт цогцолбор үйлчлүүлэх иргэдийн тоог нэмэгдүүлэх иргэдийн тоог нэмэгдүүлж, техник хэрэгслийг тогтмол нэмэгдүүлэх | Илүүдэл жингүй –Эртэч Монгол аяны хүрээнд дасгал хөдөлгөөн,эрүүл амьдралын хэв маяг, алхалт хийж нийт 1276 иргэд хамрагдаж, спорт цогцолборт секц дугуйлан 6 төрлөөр хичээллэж 120 гаруй хүүхдүүд хамрагдсан. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | 6 | 5 | | | 1 | | 89% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №11

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

| № | Үзүүлэлт | Хүрэх үр дүн | Биелэлт | |
|---|---|---|---|---|
| **Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна.** | | | | |
| 11.1 | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 52.2 | 18 ба түүнээс дээш хүн ам-3267<br>Хамрагдсан 1730 буюу 53% | 100% |
| 11.2 | Чихрийн шижин хэв шинж- 2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 92.6 | 40 ба түүнээс дээш хүн ам-1563<br>Хамрагдсан 1477 буюу 94,5% | 100% |
| 11.3 | Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 2132 | Хамрагдвал зохих зорилтот насны эмэгтэйчүүд-236<br>Хамрагдсан -195 буюу 82.6% | 100% |
| 11.4 | Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 27.7 | Хамрагдвал зохих зорилтот насны эмэгтэйчүүд-236<br>Хамрагдсан-32 буюу 13.5% | 70% |
| 11.5 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 35.1 | Нийт үзлэг 5910, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2154 буюу 39,9% | 100% |
| 11.6 | В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь | 99% доошгүй | 100% | 100% |
| 11.7 | Тавт, сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит сэргийлэх тарилгын хамралтын хувь 3-р тун | 99% доошгүй | 100% | 100% |
| 11.8 | Улаан бурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь 2-р тун | 99% доошгүй | 100% | 100% |
| 11.9 | Эхийн эндэгдлийн түвшин / 100000 амьд төрөлт тутамд/ | 0.0 | 0 | 100% |
| 11.10 | Нялхсын эндэгдлийн түвшин / 1000 | 10.0 | 0 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | амьд төрөлт тутамд/ | | | |
| 11.11 | Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 5.7 | 0 | 100% |
| 11.12 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 14.1 | 0 | 100% |
| 11.13 | Амьгүй төрөлтийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 5.0 | 0 | 100% |
| 11.14 | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь | 90.8 | 91.7 | 100% |
| 11.15 | Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин | 7.6 | 6.0 | 100% |
| 11.16 | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /10000 хүн амд/ | 7.2 | 5.7 | 100% |
| 11.17 | Вируст хепатитын өвчлөлийн түвшин / 10000 хүн амд/ | 0 | 0 | 100% |
| 11.18 | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд/ | 21.5 | 15.2 | 100% |
| 11.19 | Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд/ | 11.6 | 9.5 | 100% |
| 11.20 | Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин /10000 хүн амд/ | 1.7 | 0 | 100% |
| 11.21 | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, / бодит тоогоор/ | 0.8 | 0 | 100% |
| 11.22 | 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин /10000 хүүхдэд T20-T32/ | 22.9 | 14.1 | 100% |
| 11.23 | Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин /10000 хүүхдэд V00-V99/ | 0.7 | 0 | 100% |
| 11.24 | Шинээр ажилд авсан сувилагчийн тоо | гүйцэтгэлээр | 2022 онд 2 сувилагчийг шинээр ажилд авсан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11.25 | Хүний нөөцийг бүрдүүлэх 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь | гүйцэтгэлээр | 93.4 | 100% |
| 11.26 | Орон нутгаас байр, орон сууцаар хангасан мэргэжилтний тоо | гүйцэтгэлээр | 2022 оны байдлаар 2 их эмч, 1 сувилагч шинээр авсан бөгөөд байраар хангасаж ажилласан. | 100% |
| 11.27 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт /чиглэл, төгрөгөөр, хувиар/ | гүйцэтгэлээр | 30 сая | 100% |
| 11.28 | Сувилагч мэргэжлээр тухайн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ суралцагчийн тоо | Эрүүл мэндийн эмч мэргэжилтнийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх зорилгоор эмнэлгийн 3 мэргэжилтнийгмэргэжил олгохоор цалинтай сургаж байна. | | 100% |
| 11.29 | Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр Засаг дарга, ИТХ-ын түвшинд гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 2022 оны 12 дугаар сарын байдлаар сумын Эрүүл мэндийн төвд 2 их эмч, 1 сувилагчийн орон тоо дутуу байснаас 2 их эмч 2 сувилагч шинээр ажилд авч, 3 ажилтанд мэргэжил олгохоор сургаж байна. | | 100% |
| 11.30 | Тайлангийн жилд хүний нөөцийн чадавхийг сайжруулах нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Хүний нөөцийн чадавхийг сайжруулах ажлын байран дахь сургалтыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албаны дарга, Эрүүл мэндийн газрын эх хүүхдийн тусламж хариуцсан мэргэжилтэн нар 2022 оны 04 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 14 хүнийг хамруулсан. | | 100% |
| 11.31 | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээ /"Эрүүл идэвхтэй амьдрал", "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Халдварт бус өвчин", "Халдварт өвчин", "Орчны эрүүл мэнд болон бусад"-ыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж ажиллах | 2022 оны 12 дугаар сарын байдлаар "Эрүүл идэвхтэй амьдрал, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд","Хавдрын эсрэг", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл чийрэг эр хүн", "Халдварт бус өвчин", "Халдварт өвчин", "Орчны эрүүл мэнд" нийт 11 хөтөлбөрөөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 1 бүсийн хэмжээнд арга хэмжээ явуулж, 27 удаагийн сургалтад 857 иргэнийг хамруулсан. Гарын авлага сургалтын материал 3256 ширхгийг хэвлэж тараасан. | | 100% |
| 11.32 | Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах | 2022 онд 301 нэр төрлийн нөөцтэй байна.Тендерт258 нэр төрлийн эмийн нөөцтэй. Эмийн хугацаанд хяналтын самбар хөтөлж, хэрэглээ зарцуулалтыг сар бүр орлого зарлага санхүүгийн тайлангаар | | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | зарцуулагдаж байна. Эмийн хангалт нөөцийг чанарын шаардлага хангасан магадлан итгэмжлэгдсэн Сэлэнгэ аймаг Монгол Эм Импекс концерн, УБ хотын Ундрах чанар, Дархан-Уул аймгийн Монос- Дархан эм хanган нийлүүлэх байгууллага байгуулагатай гэрээ хийж бүрдүүлдэг. | |
| 11.33 | Ундны ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон, муу усны нүх барьж, ашиглах, нийгмийн эзэмшлийн зам, талбайд нус, цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлж ажиллах | 2022 онд Орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая төгрөгний санхүүжилтээр “Хүнх сэрээн” ХХК-аар ЭМТ-ийн бохирын их засварын ажлыг хийж гүйцэтгүүлсэн. | 100% |
| 11.34 | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үед эмнэлгийн бусад үйлчилгээний хэвийн тасралтгүй байдлыг ханган ажиллах | 2022 оны 12 сарын байдлаар ковидын 98 тохиолдол бүртгэгдсэн. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн тасралтгүй явагдсан. | 100% |
| 11.35 | Коронавируст халдвар /КОВИД-19/ харъяа нутаг дэвсгэрт бүртгэгдэн, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэт ачаалал үүсэж бусад өвчлөлийн шалтгаантай иргэд эмнэлгээр үйлчлүүлэх боломжгүй тохиолдолд анхан шатны тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэлийн чанарт хяналт тавьж ажиллах | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлж, эмчийн заавар зөвлөгөөг утсаар өгч ажилласан. Шаардлагатай тохиолдолд гэрээр очиж тусламж үйлчилгээг цаг алдалгүй хүргэсэн. | 100% |
| 11.36 | Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г зохион байгуулах | 2022 оны 12 дугаар сарын байдлаар алслагдсан багийн иргэдэд нийт 21 удаагийн эргэлт хийж , дараах тусламж үйлчилгээнд хамруулсан.Үүнд<br>• Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэг<br>• Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэг<br>• Элэгний хорт хавдар өвчлөлийн эрт илрүүлгийн үзлэг<br>0-17 насны хүүхдийн эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт давтан тоогоор 2315 иргэнийг хамруулсан байна. Мөн шаардлагатай эм тариагаар үйлчилж, Ковидын дархлаажуулалтад 213, томуугийн эсрэг дархлаажуулалтнд 112 иргэнийг хамруулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 11.37 | Хүүхдийн осол, гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, арга хэмжээний хэрэгжилтэнд байнгын хяналт тавих | Сэлэнгэ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын явуулын үйлчилгээ үзүүлэх баг сумын удирдлагуудад хүүхдийн эрх хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цаашдын ажил арга хэмжээг төлөвлөх чиглэлд санал өгч, газар дээр нь зөвлөн туслах үйлчилгээг 5 удаа үзүүлсэн. 2022 оны 12 дугаар сарын байдлаар хүүхдийн осол гэмтэл 17 бүртгэгдсэн. Осол гэмтлийг шалтгаанаар нь авч үзвэл:<br>• Зам тээврийн осол /V00-V99/-2<br>• Бүх төрлийн уналт /W00-W19/- 4<br>• Амьгүй механик хүчинд өртөсөн /W20-W49/-3<br>• Амьсгал боох аюултай бусад осол /W75-W84/-1<br>• Түлэгдэлт /W85-X19/-5<br>• Хүчирхийлэл /X85-Y09/-2 | 100% |
| 11.38 | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлэх | 2022 оны 12 дугаар сарын байдлаар 52 жирэмсэн эмэгтэйг аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүд болон төрөх тасаг руу тээвэрлэсэн. | 100% |
| 11.39 | Орон нутгийн хүн амын шилжилт хөдөлгөөнийг үнэн зөв бүртгэх, түр оршин суугч, явуулын иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллах | Түр оршин суугч болон явуулын иргэдэд харъяалал харгалзахгүйгээр эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, жигд хүртээмжтэй хүргэсэн. | 100% |
| 11.40 | Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, эрүүл мэндийн даатгалын ttps://e-hospital.mnцахим шивэлтэд бүрэн оруулсан. | 100% |
| 11.41 | Сүрьеэ өвчний илрүүлгийн хувийг зорилтот түвшинд хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 9 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд 2 өдрийн хугацаанд Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулсан. Үзлэгээр аймгаас Сүрьеэгийн эмч, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, ЭМТҮЧАБ хариуцсан дарга, рентген эмч, техникч, жолооч гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан.<br>Сүрьеэ туссан, тусаад эдгэрсэн, мөн туссан иргэний 1,2 дугаар хувьтал, мөн зорилтод бүлгийн 150 иргэний мэдээллийг гаргаж, 2 өдрийн хугацнаанд Цээжний рентгэнд шинжилгээнд хамруулж, Сүрьеэ хариуцсан нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгүүлж, өөрчлөлттэй гарсан иргэнээс цэрний шинжилгээ авчсан. Үзлэгээр зорилтод бүлгийн 208 иргэн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хамрагдснаас 9 иргэн өөрчлөлттэй гарч, цэрний шинжилгээнд хамрагдсан. 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт шинээр 3 сүрьеэ бүртгэгдсэн бөгөөд эмчийн хяналтанд эмээ ууж хэвшсэн. | |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | 41 | 41 | | | | | 100% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсраль №12

## СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Ажил, арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 12.1 | Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг чанартай зохион байгуулах. | Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, аймгийн Засаг даргын захирамжаар түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг 2022 оны 09 дүгээр сарын 17-ноос 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд явуулсан. | 100% |
| 12.2 | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын үзлэгийг зохион байгуулах. | Соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлагчдыг дэмжих зорилгоор “Монгол ёс заншил, зан үйл” –н талаар зохион байгуулж байгаа арга хэмжээндээ тусган төр, төсвийн 6 байгууллага, 11 аж ахуйн нэгж, иргэдийн дунд “Уламжлалт тоглоом наадгайг урлан хийж , наадаж сурцгаая” аяныг өрнүүлэн сумын Засаг даргаар баталгаажуулан “Цагааннуур Соёлын төв” цахим хуудсанд байршуулан нийтэд таниулан шагайгаар наадаж сурцгаая сургалтыг 6 удаа зохион байгуулж нийт 85 хүүхэд 12 насанд хүрэгчид хамрагдан “шагай таалцах”,”морь уралдуулах” ,”шагай шүүрэх”, “Есөн шарга”, “Дүрс бүтээх”, “Шагай шүүрэх” зэрэг 10 төрлийн наадгайг мэдэж сурсан.Монгол өв соёлыг таниулан сурталчлах тэдгээрийг заан сургах "Дөрвөн бэрх" тэмцээн 1 дүгээр цэцэрлэгийн багш хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. 4 багийн 16 багш хүүхдүүд оролцон 58 хүүхэд багачууд үзэж сонирхсон. “Уламжлалт тоглоом наадгайг урлан хийж , наадаж сурцгаая” аяны хүрээнд “Миний монгол наадгай” тэмцээн зохион байгуулж нийт 8 багийн 24 хүн хамрагдсан. | 100% |
| 12.3 | Хууль бус малтлагыг таслан зогсоох арга хэмжээг авах | Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тооллогоор 3 дугаар багийн нутаг дэвсгэр дээр нүхтийн амны 1 дөрвөлжин хиргисүүр 50 см, Ноён уулын 4 хиргисүүр, 1 дүгээр багийн нутаг дэвсгэр дээрх Нинждолби Номунхан хийдийн туурь 1 метр, Эрдэнэвангийн хүрээний туурь 5 метрийн гүн ухагдсан байсныг дүрсжүүлэн баримтжуулж авсан. | 70% |
| 12.4. | Түүх соёл үл хөдлөх дурсгалын хамгаалалтын дэглэм тогтоож дурсгал нэг бүрээр кадастарт оруулах. | Улсын бүртгэлд байгаа дурсгалт газруудын координатыг тогтоосон. Хамгаалалтын дэглэм тогтоож кадасдарт оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 12.5. | “Нүүдэлчин монгол” наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | Оролцох авьяастаны тооноос шалтгаалан оролцоогүй | 0% |
| 12.6. | Угийн бичиг хөтлөх ажлыг зохион байгуулах. | Ургийн бичиг" хөтлөхийн ач холбогдолын талаар 65 малчид, сумын иргэдэд мэдээлэл өгч угийн бичиг хөтлөх аргачилал номыг танилцуулсан.<br>Гэрийн угийн бичиг түүнийг хэрхэн зөн хөтлөх арга зүйн тухай цуврал 3 видео бичлэгийг “Цагааннуур Соёлын төв” цахим хуудсанд байршуулан танилцуулсан.<br>Зүүнбүрэн суманд 2022 оны 5 сард аймгийн номын сангаас “Угийн бичиг”-ийг хөтлөх сургалт явуулж Сэлэнгэ бүсийн номын санч хамрагдсан | 70% |
| 12.7 | Орон нутагт амьдардаг үндэстэн, ястны өвөрмөц ёс заншлыг агуулсан тоглолт соёлын үйлчилгээ, соёлын аялал жуучлалын бүтээгдэхүүн гаргаж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх. | Дуу, бүжгийн дугуйлан сургалтанд нийт 56 хүүхэд багачууд хичээллэж байна. МУТАА Ч.Шинэбилэгтэй хамтран “Бидний мартамгүй - Соёлын өв” сургалтын хүрээнд бүжгийн дугуйлангийн бага, дунд,ахлах бүлгийн 48 хүүхдэд “Бүжиг гэж юу вэ”, түүний ач холбогдол гарал үүслийн талаар уулзалт сургалтыг зохион байгуулсан.Мөн дууны дугуйлангийн сурагчдад Монгол ардын уртын дуу “Цомбон туурайтай” дууг заан сургасан. | 100% |
| 12.8 | Монгол бичгийн өв соёл, сурвалж судалгааг суртчилах, Монгол бичгээр дагнан үзэсгэлэн, арга хэмжээг зохион байгуулах. | **“Үндэсний бичиг соёлын өдөр”**-г тохиолдуулан Монгол үндэсний хэл бичгээрээ цэвэр сайхан бичих сурч эзэмших хүсэл эрмэлзлийг бадраах, хөхүүлэн дэмжих, бичих чадварыг нэмэгдүүлэх зорилготой **“Сайхан бичигтэн”, “Цэвэр бичигтэн”** шалгаруулах тэмцээн, төрийн албан хаагчид иргэдийн дунд шударга уншлагын тэмцээнийг зохион байгуулсан.<br>Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд “Босоо Монгол бичиг минү” сургаал,зүйр цэцэн үгсийн уран бичлэгийн уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангилалаар зохион байгуулан нийт 14 хүүхэд 8 насанд хүрэгчийг хамруулсан.<br>"Миний нутаг” шүлгийг монгол бичгээр цэвэр сайхан бичих вэ? Уралдааныг төсвийн байгууллагын ажиллагсадын дунд зохион байгуулж 26 албан хаагчийг хамруулсан. Мөн 106 гаруй иргэн, хүүхдийн бүтээлийн үзэсгэлэнг гарган нийтэд танилцуулсан. | 100% |
| 12.9 | Хос бичигтэн байгууллага болох арга хэмжээг хэрэгжүүлэх. | Монгол үндэсний хэл бичгийг бүх нийтийн хүртээл болгон зорилгоор иргэд, хүүхэд,залуучуудын дунд 6 арга хэмжээг ЕБС-н хэл уран зохиолын багш нартай хамтран зохион байгуулсан.<br>Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд “Босоо Монгол бичиг минү” сургаал,зүйр цэцэн үгсийн уран бичлэгийн уралдааныг хүүхэд, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангилалаар зохион байгуулан нийт 14 хүүхэд 8 насанд хүрэгчийг хамруулсан.<br>"Миний нутаг” шүлгийг монгол бичгээр цэвэр сайхан бичих вэ? | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| | | уралдааныг төсвийн байгууллагын ажиллагсадын дунд зохион байгуулж 26 албан хаагчийг хамруулсан. Мөн 106 гаруй иргэн, хүүхдийн бүтээлийн үзэсгэлэнг гарган нийтэд танилцуулсан. | |
| 12.10 | Өв соёлын өргөө, соёлын төв, дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж, соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалт, бүтээлч үйлдвэрийг дэмжих. | Дуу, бүжгийн дугуйлан сургалтанд нийт 56 хүүхэд багачууд хичээллэж байна. МУТАА Ч.Шинэбилэгтэйхамтран “Бидний мартамгүй - Соёлын өв” сургалтын хүрээнд бүжгийн дугуйлангийн бага, дунд, ахлах бүлгийн 48 хүүхдэд “Бүжиг гэж юу вэ”, түүний ач холбогдол гарал үүслийн талаар уулзалт сургалтыг зохион байгуулсан. Мөн дууны дугуйлангийн сурагчдад Монгол ардын уртын дуу “Цомбон туурайтай” дууг заан сургасан. | 100% |
| 12.11 | Хүүхэд залуучууд, ардын авъяастан, соёлын өвийг өвлөн уламжлагчдыг олон улс, улс, аймгийн чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх. | Нэрт яруу найрагч Г.Сэр-Одын нэрэмжит "Дунгийн эгшиг" өсвөрийн яруу найрагчдын 32 дахь жилийн наадамд 8-9-р ангийн төрөлд 9в ангийн сурагч Ж.Төвсайхан , 6-7-р ангийн төрөлд 7б ангийн сурагч С.Отгонзаяа нар шалгаран оролцож, 9в ангийн сурагч Ж.Төвсайхан тэргүүн байр эзэлсэн. | 50% |
| 12.12 | Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлж буй иргэн, ах ахуй нэгж, хуулийн этгээдийн санал санаачлага, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, урамшуулах | Соёлынбүтээлчүйлдвэрлэлийгхөгжүүлэхзорилгоорхүүхэд, иргэд болон эмэгтэйчүүдийн дунд “**ПОЛИМОР”** урлал болон **“Нэхмэл гутал”-**ын гар урлалын сургалтыг сургагч багштай нартай хамтран зохион явуулсан.Бэлэг дурсгалын зүйлс болон шүрэн эдлэлийн урлалыг эзэмшигч 4 иргэний бүтээлийн үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулсан. ЗДТГ-тай хамтран “Цагааннуур суманд үйлдвэрлэв” гар урлал,сүү сүүн бүтээгдхүүн,төмс хүнсний ногооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.<br>Мөниргэдийн“Дундсоёлынбүтээлчүйлдвэрлэл”уралдаанзарлажнийт6 иргэний бүтээлийнолоннийтэдтанилцууланурамшуулсан. | 100% |
| 12.13 | Соёл урлагийн байгууллагууд ERP систем, цахим үйлчилгээг нэвтрүүлэх сугалтанд хамруулах, нийгмийн баталгааг сайжруулах. | Тус ажлын хүрээнд Цагааннуур сумын Соёлын төв нь шинээр Веб хуудастай болсон ба байгууллагын танилцуулга, соёлын болон олон нийтийн үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдал, түүх соёлын дурсгалт газар, номын сангийн үйл ажиллагааг тогтмол нийтэлж байна. Мөн аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан ERPMongolia сургалтад номын санчийг хамруулсан. | 70% |
| 12.14 | Соёл урлагийн байгууллагад шаардлаатай хөгжим техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах. | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шалны паркет, акустак хавтан шинээр авч үзвэрийн танхимыг засварласан. Мөн 4,5 сая төгрөгийн хөрөнгөөр техник тоног төхөөрөмжийг шинэчиллээ. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| № | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| **СОЁЛ УРЛАГИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 14 | 8 | 4 | 1 | | 1 | 75% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсраль №13

## ХҮН АМ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ

| № | Ажил, арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| **1. Гэр бүл, хүүхэд залуучууд** | | | |
| 13.1.1 | Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?, Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хаана хандах вэ?, Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэл болон үе тэнгийн дарамт, дээрэлхэлт, анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх вэ? зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж 32 сурагч хамруулсан.Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор харилцаа хандлага, төлөвшил, гэр бүл төлөвлөлт сэдвээр 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр сургуулийн 9-12 дугаар ангийн 380 сурагчид сургалт зохион байгуулсан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөлийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсуудыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан. Сумын хамтарсан баг архины хамраалалтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн.<br>Сургуулийн сэтгэлзүйч хараа хяналт сул, архины хамааралтай айл өрх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлт нөхцөлд амьдарч буй 9 сурагчтай ганцаарчилсан ярилцлага хийж зөвлөн тусалсан.<br>Сумын хамтарсан баг архины хамааралтай 5 өрхөд давхцсан тоогоор 18 удаа гэрээр нь очиж эргэлт хийж үйлчилгээ үзүүлсэн. 9 сурагчийн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | амьдрах орчинд нөхцөл байдлын үнэлгээг хийх, эрсдлээс урьдчилан сэргийлж арга хэмжээ авч ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 3 сурагчийн эцэг эх, асран хамгаалагчтай уулзаж ярилцлага хийж зөвлөн тусалсан. | |
| 13.1.2 | “Хүчирхийлэлгүй аймаг” уриалыг дэмжиж “ Хүчирхийлэлгүй баг, сум” аяныг өрнүүлж, үр дүнг тооцох | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөлийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийлийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсуудыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан. Сумын хамтарсан баг архины хамраалалтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн. Архины хамааралтай хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлж буй 2 иргэнийг архинаас гаргах эмчилгээнд хамруулсан. | 100% |
| 13.1.3 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, залуучуудын хөгжлийн зөвлөл, залуучуудын элчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган тайлагнах | Монголын Залуучуудын өдрийг тохиолдуулан "Хүртээмжит нийгэм-залуусын оролцоо-хөдөлмөр эрхлэлт" залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд "Орон нутгийн залуусаа сонсъё" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 30% |
| 13.1.4 | Хүүхдийн төлөө зөвлөлийн дүрэм төлөвлөгөөний хэрэгжилтийн ханган орчинд урьдчилан сэргийлэх хяналт тавих | Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг гарган ажиллаж байна. | 100% |
| 13.1.5 | Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулан, сайн туршлагыг судлах, орон нутагаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Аймгийн гэр бүлийн газрын ажилтан болон цагдаагийн газрын алба хаагч нартай 2 удаа сургалт зохион байгуулж мэдээлэл солилцон хамтран ажилласан. Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ГБХЗХГ-аас зохион байгуулагдсан НАМС-ын сургалт, Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, “Хүүхэд хамгааллын кейс менежмент”, “НАМС-ыг ашиглах нь”зэрэг сургалтуудад хамрагдсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хамтарсан багийн үйл ажиллагааг сурталчилах, хамтран ажиллахад хүн бүрийн оролцоо маш чухал гэдгийг сурталчлах зорилгоор сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сургалтыг зохион байгуулсан. | |
| 13.1.6 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг дэмжин, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин бүрдүүлэх | 1 дүгээр цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг нь анги бүлгүүдийн зорилтот өрхийн хүүхдийн судалгааг гарган багш нар 1:1 удаа гэрээр эргэлт хийж нөхцөл байдлын талаархи мэдээллийг цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багт танилцуулж ажилласан. Дээрх гэр эргэлтээр ажилласан судалгаанд дээр үндэслэн хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцооны чиглэлээр эцэг эхийн дунд сургалт зохион явуулж давхардсан тоогоор 72 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан.Мөн хамт олны санаачлага, дэмжлэгээр нэг ангийн орны өрөөг шинээр тохижуулж хүүхэд өөрөө үйлийн эзэн нь байх, тоглонгоо чадвар эзэмших, өөрөө өөртөө үйлчлэх хөдөлмөрт сургах “БИ ӨӨРӨӨ” өрөөг шинээр бүтээн байгуулсан. Уг өрөөнд хүүхдүүд сонголтын булангийн цагаараа орж багшийн дэмжлэг тусламжтай хоол хийх, өндөг чанах шарах, ногоо арилгах, салат, зууш бэлтгэх энгийн чадварт суралцах, аяга тавгаа хурааж угааж, арчих, өөрсдийн хамрын алчуураа угаах, индүүдэх, хүүхэлдэйн оймсыг угаах, энгийн оёдол эсгүүр хийх, мужааны хөдөлмөрт суралцах зэрэг өөрөө өөртөө үйлчлэх хөдөлмөрт суралцаж байна.<br>2 дугаар цэцэрлэг нь “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”-ын хүрээнд хүүхэд хамгааллын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж ажлын төлөвлөгөө гарган бага насны хүүхдийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол илэрсэн, эсхүл хүүхдийн эсрэг хүчирхийлэл илэрч болзошгүй тухай мэдээлэл, сэжиг таамгийг хүлээн авах, хариу үйлчилгээ үзүүлэх, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хяналт үнэлгээ хийн ажиллаж доорх ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Цэцэрлэгийн захиргаа сумын Хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллаж, хүүхэд хамгаалах чиглэлээр хийгдэх 14 төрлийн судалгааг цэцэрлэгийн хэмжээнд боловсруулан гаргаж ажилласан ба багш бүр хүүхэд хамгаалах хавтастай болсон. Мөн хүүхдийн гэрээс цэцэрлэг хүртэлх маршрутыг гаргаж эрсдэлд өртөж болзошгүй газрыг нь тогтоож зам талбайг янзлах, хаягжуулах, болгоомжлох тэмдэг тэмдэглэгээг тухай бүрд нь байрлуулж | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | цэцэрлэгийн гадна талын засмал замаас цэцэрлэг рүү орох 150 м замыг сайжруулсан зам болгосон.<br>ЕБС-ийн хүүхэд хамгааллын баг нь сумын хамтарсан багтай байнгын уялдаа холбоотой ажиллаж байна. Хүүхдийн сурч боловсрох орчин нөхцлийг сайжруулах зорилгоор 8-12-р ангийн охидтой уулзалт зохион байгуулж сургуулийн орчинд охидын тулгамдаж буй асуудал түүнийг хэрхэн даван туулах талаар ярилцлага хийснээр охидийн ариун цэврийн өрөөг суманд үйл ажиллагаа явуулж буй 2 дэлгүүрийн тусламж дэмжлэгээр тохижуулсан.<br>БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, Сэлэнгэ аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд багш, сурагчдын мэдээллийн технологийн чадавхийг нэмэгдүүлэх зорилготойгоор мэдээлэл зүйн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий тохилог анги танхимаар хангагдсан. Уг ажлын үр дүнд сурагчдын мэдээллийн технологийн мэдлэг, чадвар нэмэгдэхийн зэрэгцээ багш нарын заах арга зүй болон IT мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм. | |
| 13.1.7 | Байгууллагын эцэг эхийн зөвлөлүүдийг шинээр байгуулж, зөвлөлүүдийн дунд идэвхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах | Хэрэгжээгүй | 0 |
| 13.1.8 | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн санг шинэчлэх, хамгаалалын үйлчилгээ үзүүлэх | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн санг шинэчлэх хүсэлтийг аймгийн ГБХЗХГ-т хүргүүлж шинэчилсэн. Сургуулийн сэтгэлзүйч хараа хяналт сул, архины хамааралтай айл өрх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлт нөхцөлд амьдарч буй 9 сурагчтай ганцаарчилсан ярилцлага хийж зөвлөн тусалсан.<br>Сумын хамтарсан баг архины хамааралтай 5 өрхөд давхцсан тоогоор 18 удаа гэрээр нь очиж эргэлт хийж үйлчилгээ үзүүлсэн. 9 сурагчийн амьдрах орчинд нөхцөл байдлын үнэлгээг хийх, эрсдлээс урьдчилан сэргийлж арга хэмжээ авч ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 3 сурагчийн эцэг эх, асран хамгаалагчтай уулзаж ярилцлага хийж зөвлөн тусалсан. | 100% |
| 13.1.9 | Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хүүхэд ээлтэй байдлаар боловсруулж, хэрэгжүүлэх, бүх шатны боловсролын | 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Пүрэв гарагт орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг зохион байгуулсан. Уг дадлага сургуулилтын хүрээнд ЕБС болон СӨБ-ийн сурагчдыг цугларах цэгт жагсаан газар хөдлөлт болон аливаа гамшгийн үед хэрхэн хор хохирол багатай даван | 70% |

| | | | |
|---|---|---|---|
| | байгууллагад гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтыг хэрэгжүүлэх | туулах, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах талаар мэдлэг чадварыг эзэмшүүллээ. Мөн багш нараар дамжуулан сургууль, цэцэрлэг дээр дадлага сургуулилтыг хийж ажилласан. | |
| **2. Нийгмийн хамгаалал** | | | |
| 13.2.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих | 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр халамжийн үйлчилгээ, сумын эрүүл мэндийн төв, Урианхай Шүрэн Уул ХХК-тай хамтран нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын хөнгөлөлт чөлөөлөлт бусад хууль сурталчлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг витаминжуулалтанд хамруулж мэдээлэл хүргэн ажиллаж нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 36 иргэнийг хамруулан мэдээ, мэдээлэл өгч сургалт зохион байгуулж ажилласан.<br>2022 оны 10 дугаар сарын 16 ны өдөр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд нийгмийн даатгалын мэргэжилтэн, Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн нар хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой мэдээ мэдээлэл хийж, 2022 онд хийгдсэн ажлын тайлангаа танилцуулж, үзэл бодлоо солилцон 38 даатгуулагч сургалтад хамрагдсан. | 100% |
| 13.2.2 | Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын барилга, байгууламж, нийтийн тээвэр, зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Сумын төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэнийг байгууллагад орох нөхцөл боломжоор хангаж налуу зам хийсэн. | 50% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| 1 | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ХҮН АМ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ** | | 11 | 7 | 1 | 1 | 1 | 1 | 78% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсраль №14

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Ажил, арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| | | **1.Хөдөлмөр эрхлэлт** | |
| 14.1.1 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг ажилд зуучлан ажлын байраар хангаж, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түтгэлзүүлэх ажлыг зохион байгуулах | 2022 оны эхэнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 34 өрхийн 83 том хүн, 102 хүүхэд нийт 185 иргэнд олгож байсан бол жилийн эцсийн байдлаар Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 22 өрхийн 53 том хүн, 78 хүүхэд нийт 131 иргэнд олгож 29.1 хувиар бууруулаад байна. “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд байнгын болон түр ажлын байранд 30 иргэнийг зуучилж ажилласан. | 100% |
| 14.1.2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, суулгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах модны санхүүжилт болон иргэдэд мод тарих арга аргачлал, ач холбогдлын талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах | Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний газар, сумын Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашааны нүхийг ухаж шонг суулгах, будах, хашааны төмөр тор татах, мод тарих 3 удаагийн нийтийг хамарсан ажлыг 5-7 хоногийн хугацаатайгаар хөдөлмөрийн гэрээ байгуулж, давхардсан тоогоор ажилгүй 30 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилалаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажилчдад 4.3 сая төгрөгийн цалин, ХАБЭА-н зардалд 105 мянган төгрөгийг олгосон. | 100% |
| 14.1.3 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дэмжлэгт иргэн, аж ахуй нэгжүүдийг хамруулж байнгын ажлын байр бий болгох | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн LMIS программд идэвхтэй ажил хайгчаар 130 иргэн, ажил олгогч 45 ААНБайгууллага, шинэ ажлын байранд 88 иргэн, зуучлалаар 83 иргэнийг бүртгэсэн.<br>Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, Халамж Үйлчилгээний газар, сумын Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хашааны нүхийг ухаж шонг суулгах, будах, хашааны төмөр тор татах, мод тарих 3 удаагийн нийтийг хамарсан ажлыг 5-7 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хоногийн хугацаатайгаар хөдөлмөрийн гэрээ байгуулж, давхардсан тоогоор ажилгүй 30 иргэнийг түр ажлын байраар ханган ажилалаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажилчдад 4.3 сая төгрөгийн цалин, ХАБЭА-н зардалд 105 мянган төгрөгийг олгосон | |
| 14.1.4 | Аж ахуй нэгж байгууллага, иргэдэд сурталчлах "ХАБЭА-ын сарын аян-2022" арга хэмжээг зохион байгуулах | Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт салбар хорооны 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн албан тоот, сумын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн удирдамжийн дагуу тус суманд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аянг зохион байгууллаа.<br>Тус аяны хүрээнд төрийн байгууллага болон хувийн аж ахуй нэгж байгууллагаар хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулан ажиллаж байгаа эсэх, ажилтны ажлын байрны эрүүл, аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. | 50% |
| | | **2.Нийгмийн даатгал** | |
| 14.2.1 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх | 2022 онд 1.478.591.56 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл хуримтлуулахаас 1.232.594.81 мянган төгрөг хуримтлуулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 1.106.987.81 мянган төгрөг, сайн дурын даатгалын санд 103.132.04мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 22.474.954мянган төгрөг нийт шимтгэлийн орлогын төлөвлөгөө1.232.594.81мян төгрөгийг хуримтлуулсан. | 100% |
| 14.2.2 | Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх | 2022 онд 482.455.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс 22.474.9 мян төгрөгийн орлого хуримтлуулсан. | 50% |
| 14.2.3 | Шинээр шимтгэл төлөгч ажил олгогчдын тоог нэмэгдүүлэх | 2022 оны 5 дугаар сард шинээр ажил олгогч "Товхонжимс" ХХК аж ахуй нэгж байгууллагыг нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар хамруулсан. | 30% |
| 14.2.4 | Шинээр албан журмын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх | Шинээр 25 даатгуулагч сайн дурын даатгалд хамруулсан. | 100% |
| 14.2.5 | Шинээр сайн дурын даатгалд даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх | Шинээр 77 даатгуулагч сайн дурын даатгалд хамруулсан. Үүнд хувиараа хөдөлмөр эрхлэгч 12, ажил хөдөлмөр эрхлээгүй 16, 3 хүртэлх насны хүүхдээ харж буй эх 13, малчин 31 даатгуулагч хамрагдсан. | 100% |
| 14.2.6 | Шинээр сайн дурын даатгалд хамруулах малчдын тоог нэмэгдүүлэх | 2022 онд шинээр 31 малчин даатгуулсанаас 27 малчин, 3 хүртэл насны хүүхдээ асарч буй малчин эх 4 хамруулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 14.2.7 | Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн даатгалд 640 даатгуулагч хамруулахаас 482 даатгуулагч хамруулсан. | 70% |
| 14.2.8 | Шимтгэлийн хуримтлагдсан өр авлагыг 20-оос доошгүй хувиар бууруулах | Өр авлага 71.944.79 мянган төгрөгөөр бууруулахаас 101.774.77 мянган төгрөг буюу 140%-иар бууруулсан байна. | 100% |
| 14.2.9 | Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх | Сар бүрийн нийгмийн даатгалын сангийн болон өр авлагын мэдээ бусад тайлан мэдээг хариуцсан албан тушаалтанд хугацаанд нь гаргаж хүргүүлж өр үүсгэхгүй ажилласан. | 100% |
| 14.2.10 | Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах | Дээд шатны байгууллагаас нийгмийн даатгалын хууль тогтоомж, заавар журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон шинээр гарсан хууль тогтоомж, журмыг цаг алдалгүй түргэн шуурхай иргэд, даатгуулагчдад мэдээллэн ажиллаж байна.<br>2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр халамжийн үйлчилгээ, сумын эрүүл мэндийн төв, Урианхай Шүрэн Уул ХХК-тай хамтран нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын хөнгөлөлт чөлөөлөлт бусад хууль сурталчлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг витаминжуулалтанд хамруулж мэдээлэл хүргэн ажиллаж нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 36 иргэнийг хамруулан мэдээ, мэдээлэл өгч сургалт зохион байгуулж ажилласан.<br>2022 оны 10 дугаар сарын 16 ны өдөр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн хүрээнд нийгмийн даатгалын мэргэжилтэн, Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн нар хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой мэдээ мэдээлэл хийж, 2022 онд хийгдсэн ажлын тайлангаа танилцуулж, үзэл бодлоо солилцон 38 даатгуулагч сургалтад хамрагдсан. НДЕГазраас ирсэн удирдамжийн хүрээнд сумынхаа ажил олгогч, нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сургалтыг явууллаа. Нийт 2 удаа сургалт зохион байгуулсан. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 14 | 10 | 1 | 2 | 1 | | 86% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №15

## ТӨСӨВ САНХҮҮГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Ажил , арга хэмжээ | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| 15.1 | Санхүү , төсвийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан заавар журмыг үндэслэн өөрийн харьяа нутаг дэвсгэрт арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангаж , үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцах | Төсөвт байгууллагын дарга , нягтлан бодогч , эд хариуцагч нарт санхүү төсвийн талаар гарсан тогтоол , журам , албан тоот бичгийн дагуу цаг түхай бүр мэдээллийг хүргэж шуурхай удирдлагаар ханган ажиллаж байна. 2022 оны төсвийн жил эхэлсэнтэй холбогдуулан Засаг даргын хамт төр төсвийн байгууллагын нягтлан бодогч, эд хариуцагч нартай биечлэн уулзаж төсвийн чиг үүрэг , авлага , өглөг , ТАЦНСистем , төрийн сангийн өдөр тутмын орлого зарлагын гүйлгээ, бусад цаг үеийн асуудлын талаар арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.Сар бүр удирдлагуудад төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг танилцуулж байна. | 100% |
| 15.2 | Аймгийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарилалтыг үндэслэн сумын төсвийн байгууллагын сар , улирлын хуваарилалтыг батлан мөрдөж ажиллана. Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудын төлбөр тооцооны үйлчилгээг сар , улирлын батлагдсан хуваарийн дагуу сумын төрийн сангийн дансаар дамжуулан анхан шатны баримтыг нягтлан шалгаж хүргэх. | Аймгийн Засаг даргын 1 болон 4 дүгээр сарын сар улирлын хуваарилалтын захирамжийн дагуу сумын Засаг даргын 2022 оны тодотгосон төсвийн / 1,4, сард 2 удаа / болон төсвийн зохицуулалт / 5, 10 сард 2 удаа / хийж байгууллагуудын сар , улирлын хуваарилалтыг батлан хуваарийн дагуу орон нутгийн байгууллагуудын санхүүжилт, улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилт, улсын төсвийн байгууллагуудын гүйлгээг төрийн сангийн дансаар дамжуулан анхан шатны баримтыг үндэслэн 3206 ширхэг гүйлгээ, 5.668.050.1 мян.төг-ний төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 15.3 | Аудит болон хяналт шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шалгалтын зөрчил дутагдлыг арилгаж , цаашид давтан алдаа дутагдал гаргахгүй ажиллах. | Төрийн аудитын газрын хяналт шалгалтын дүгнэлтээр “ ЗӨРЧИЛГҮЙ “ санал дүгнэлт авсан.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг аудитын газар болон санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан. | 100% |
| 15.4 | Төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавин улсын болон орон нутгийн төсвийн орлогыг хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлэх. | Сумын татварын орлогын 4 дүгээр улирлын төлөвлөгөө 954011.2 мян.төг гүйцэтгэл 805120.0 мян.төг буюу 84.5 хувийн биелэлттэй байна.Орлогыг сар бүр татварын байцаагчтай нэр төрлөөр тулган баталгаажуулан орлогыг төрийн сангийн програмд шивж байна. Давсан орлого түгээмэл тархацтай АМАТөл, ойгоос хэрэглээний мод бэлтгэх төлбөрийн хураамж,хүү торгуулийн орлого давж биелэсэн. Тасарсан | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | товарын орлогууд нь малын тоо толгойн АТ, цалин хөлсний орлого, хадгаламж хүүгийн орлого, газрын төлбөр, хогны төлбөр хураамж зэрэг орлогууд голлон нөлөөлсөн. | |
| 15.5 | 2023 оны төсвийн төсөл , 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн дагуу иргэд , олон нийтийн оролцоог ханган, хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн зарчмын дагуу хуулийн хугацаанд Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлэн хянуулах. | Төсвийн тухай хуулийн цаглаврын дагуу 2023 оны төсвийн төсөл, төсвийн төсөөллийг татварын орлогыг нэр төрлөөр, сумын 8 төсөвт байгууллага тус бүрээр төсвийн орлого , зарлагыг төсвийн гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөн, холбогдох анхан шатны баримтуудыг хавсарган аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Төсвийн төслийг шилэн данс болон tsagaannuur.gov.mn веб хаяг, мэдээллийн самбарт байршуулсан. | 100% |
| 15.6 | Төсвийн гүйцэтгэлийн сар , улирлын мэдээ хагас бүтэн жилийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу гаргаж иргэд олон нийтэд мэдээллэж , Санхүү , төрийн сангийн хэлтэст ирүүлэх. | Төсвийн тухай хуулийн цаглаврын дагуу 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны хагас жилийн, 3-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нэгтгэн Санхүү төрийн сангийн хэлтэст цаасаар болон цахим програмаар тайланг тулган баталгаажуулсан. Мөн шилэн данс болон сумын цахим веб сайт-д санхүүгийн тайлан мэдээллийг нийтэлсэн. | 100% |
| 15.7 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах болон шуурхай удирдлагаар хангаж ажиллах, төсөвт байгууллагын шилэн дансны мэдээллийн үнэн зөв , бодит байдалд хяналт тавин ажиллах. | Шилэн дансны хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллага бүрээр мэдээллийн үнэн зөв , бүрэн оруулсаныг хяналт тавин ажиллаж байна.Мөн сумын вэб сайтд төсвийн мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод , үнэн зөв мэдээлж байна. 2023 оноос шилэн дансны шинэ цахим хуудас шинэчилэгдэж төсөвт байгууллагууд бүгд шинээр байгууллагын мэдээллээ шинэчлэн бүртгүүлсэн.Шилэн дансны 3 удаагийн цахим сургалтад нягтлан бодогч нар хамрагдсан . | 100% |
| 15.8 | Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль , Төсвийн ерөнхий , ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмыг мөрдөн сумын Санхүүгийн албаны даргыг аймгийн Засаг даргатай, төсвийн байгууллагуудын нягтлан бодогчийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү , төрийн сангийн хэлтсийн даргатай тус тус зөвшилцөн томилж , чөлөөлөх болон Санхүүгийн албаны боловсон хүчний тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллах. | 2022 онд ЗДТГ-ын 1 нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдөж , шинээр авсан нягтлан бодогчийг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөн зөвшөлцлийн хариу албан тоот авсан.3 эд хариуцагч ажлаас чөлөөлөгдөж сумын санхүүгийн албаны даргатай зөвшөлцөн зөвшөлцлийн дагуу боловсон хүчний ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 15.9 | Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд аж , ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хэрэгжилтийн байдалд зөвлөгөө өгөх.Нягтлан бодох бүртгэлийн хууль, Аудитын тухай хууль болон холбогдох заавар журмыг сурталчлах , аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан хуулийн хугацаанд нэгтгэгдэж байгаа байдалд холбогдох санхүүгийн тайлангийн нэгтгэлийн програмаар дамжуулан хяналт тавих. | Сумын аж ахуйн нэгжийн 2021 оны жилийн эцсийн тайлан өгөхтэй холбоотой нийт 95 ААН-тэй утсаар холбогдон сануулсан. 2022 оны хагас жилийн тайлан өгөх 25 ААН-тэй утсаар холбогдон сумын цахим веб сайтад тайлан илгээх мэдээ мэдээллийг нийтэлсэн.Бүртгэлгүй байсан 3 ААН-ийг бүртгүүлж, ААН-ийн судалгаа гарган Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. | 100% |
| 15.10 | Төрийн сангийн тогтолцооны цахим шилжилтийн бодлого, зорилтын биелэлтийг хангаж , төлбөр тооцооны үйл ажиллагааг цахимжуулах үйл ажиллагааг зохион байгуулах. | Эрхийн бүртгэлийн санд төсөвт байгууллагууд болон байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарын эрхийг цахимаар бүртгэлжүүлэн бүрэн холбосон. ТАЦНСистемээр дамжуулан 8 төсөвт байгууллагын цалинг цалингийн нэгдсэн системээр дамжуулан олгож байна. | 100% |

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

| 1 | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ТӨСӨВ САНХҮҮГИЙН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 10 | 10 | | | | | 100% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт №16

## СТАТИСТИКИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

| | Ажил , арга хэмжээ | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| 16.1 | 2022 оны сумдаас нэгтгэж ирүүлэх албан ёсны статистикийн 55 төрлийн мэдээг, 296 удаагийн давтамжтайгаар үнэн зөв бодитой, цаг хугацаанд нь гаргаж аймгийн Статистикийн хэлтэст ирүүлэх. | Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/09 тоот захирамжийн дагуу мэдээ, тайлан гаргах албан тушаалтныг баталж, батлагдсан хуваарийн дагуу хариуцсан албан тушаалтнаар гаргуулан цаг хугацаанд нь үнэн зөв бодитой гарган аймгийн Статистикийн хэлтэст цаасаар болон онлайнаар хүргүүлсэн. | 100% |
| 16.2 | Албан ёсны статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгааны баталгаажуулалт, үнэн бодит байдал, чанар, хүртээмжийг дээшлүүлэх. | Албан ёсны статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгааг холбогдох албан тушаалтнаар баталгаажуулан, үнэн зөв гарган аймгийн Статистикийн хэлтэст цаасаар болон онлайнаар хүргүүлэн үр дүнг мэдээллийн самбар болон гарын авлагаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. | 100% |
| 16.3 | Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн“ Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай” 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх | Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “ Анхан шатны статистик мэдээ тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай” 05 тоот албан даалгаврыг хэрэгжилтийг хангаж, анхан шатны статистик мэдээ, тайланг цаг хугацаанд нь чанартай хийж ажилласан. | 100% |
| 16.4 | Хүн ам, өрхийн мэдээллийн онлайн сан дээр өрх, иргэний бүртгэл, мэдээлэл, хөдөлгөөн өөрчлөлтийг багийн Засаг дарга нараар цаг тухай бүрт нь хөтлүүлж, сангаас гарах тайлан мэдээг аймаг , сумын түвшинд ашиглуулах. | ХАӨМС-ийн шинэчлэлт, хувь хүний үзүүлэлтийн алдаа , байршил тодорхойлоогүй өрх, мэдээллийн санд оруулаагүй 79 хүүхэд , иргэний мэдээллийн санд нас барсан 24 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 190 иргэний мэдээллийг шинэчилж, баяжилтыг 7 хоног бүр шалгаж алдааг засварлан тухай бүр шинэчлэлтийг хийж, хүн ам өрхийн мэдээллийн сангаас гарах мэдээ тайланг сумын түвшинд ашиглуулан ажиллаж байна. | 100% |
| 16.5 | Өрхөд суурилсан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, “Ажиллах хүчний судалгаа”, болон бусад судалгааг явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах / сонгогдсон багт хөтөч ажиллуулах / | Сэлэнгэ аймгаас судалгааны баг ажиллах хүчний түүвэр судалгааг1, 2 дугаар багийн 10 өрхөөс 6 удаа, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 1, 3 дугаар багийн 8 өрхөөс 1 удаа авсан ба багийн дарга нарыг хөтчөөр ажиллуулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 16.6 | Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого болон бусад тооллогыг орон нутагтаа чанартай, үр дүнтэй зохион байгуулж, шаардлагатай санхүүжилт, хүн хүч, техник хэрэгслээр хангах, туслалцаа үзүүлэх | Аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу хагас жилийн Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу удирдлага зохион байгуулалтаар ханган, Хөдөө аж ахуйн ээлжит тооллогодоо давхцуулан 2022 оны 06 дугаар сарын 02-ноос 15-ны хооронд 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг амжилттай зохион байгуулсан. Тооллогод нийт 276 өрх, 11 аж ахуйн нэгж хамрагдаж тооллогын дүнг хуваарийн дагуу аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн “Мал тэжээвэр амьтдын улсын тооллого” -ыг 12 сарын 07-ноос 17-ны хооронд 24 хэсэгт 49 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гаран ажиллаж байна. | 100% |
| 16.7 | Хуулийн дагуу 10 жил тутам зохион байгуулагддаг “Хөдөө аж ахуйн тооллого”-г сумандаа зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангах | Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тооллогын комисс нь сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/69 тоот захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан давхардсан тоогоор 402 өрх, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг тооллогод хамруулсан. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| 1 | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| **СТАТИСТИКИЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 7 | 7 | | | | | 100% |

Цагааннуур сумын Засаг даргатай хамтран
ажиллах гэрээний хавсралт № 17

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ**

| № | Ажил, арга хэмжээ | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 17.1 | Төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах | ЗДТГ-ын дарга нь ажлын өрөөндөө төмөр сейф байршуулан нууцын баримт бичгийг хадгалж лац тэмдгийг тогтмол хэрэглэж хэвшсэн. Хууль эрх зүйн ажилтан, Архив бичиг хэргийн ажилтан багийн Засаг дарга нарын ажлын компьютерт вирусийн программ суулгасны дээр ажилтнуудын нууцын зэрэглэлтэй файлуудыг паспортжуулсан. | 100% |
| 17.2 | Батлан хамгаалах багц хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Дайчилгааны тухай хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүлэх, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах | Засаг дарга, ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга холбогдох албан хаагчид хамтран батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ЦШ-аас ирүүлсэн захирамж шийдвэр, үүрэг чиглэлийг иргэдэд сурталчилах, хэрэгжүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулан хэрэгжилтийг ханган тайлан мэдээг хугацаанд нь хүргэн ажиллаж байна.<br>Холбогдох хууль дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг чиглэлийг мэдээллийн самбар болон сумын албан ёсны цахим хуудсаар мэдээллийг хүргэн ажиллалаа. | 100% |
| 17.3 | Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний анги, салбарт хугацаат цэргийн алба хаасаар эх орны томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцож мэргэшсэн боловсон хүчин болж бэлтгэгдэх талаар цэргийн насны залуучуудад сурталчлан таниулах | Цэргийн тоо бүртгэлийн үеэр шинээр 18 нас хүрсэн залуусыг бүртгэлд идэвхтэй хамруулах талаар багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж шинээр Цэргийн үүрэгтний үнэмлэх бичиж олгох ажлыг зохион байгуулсан.<br>2022 оны 1 болон 2 дугаар ээлжийн цэрэг татлагын үеэр зарлан дуудах хуудас авсан цэргийн 2 дугаар зэргийн үүрэгтэн залуучуудад цэргийн алба хаахын ач холбогдол эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцох талаар цэргийн алба хаасан залуучуудаар яриа таниулга хийх ажлыг 2 удаа зохион байгуулсан.<br>Цэргийн анги салбарт алба хааж буй залуучуудын ар гэрийг тангаргийн баярт ороолцоход нь сумын ЗДТГ-аас дэмжлэг үзүүлэн ажиллалаа. | 100% |
| 17.4 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэгжилтийн спортын цогцолбор “Дөл-2022” тэмцээний | Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10-11 дүгээр ангийн 3 бүлгийн хүүхдүүдийн дунд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын Дөл тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгуулж 11а | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | эхний шатыг сумандаа зохион байгуулж шалгарсан сурагчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэж оролцуулах | ангийн “Хангарьд” баг тэргүүн байр эзлэн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан. Бүсийн 3 сум Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн сумдын ЕБС-ийн хүүхдүүдийн цэрэг спортын Дөл тэмцээнийг суманд 5 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулж Зүүнбүрэн сумын баг тэргүүн байр эзлэн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан. Сум бүсийн аварга шалгаруулах Дөл тэмцээнийг зохион байгуулахад сумын ЗДТГ-ын төсөв болон Засаг даргын нөөцөөс 500,000 төгрөгийн шагналын зардал гарсан. | |
| 17.5 | Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | 2022 оны 08 дугаар сарын 03-06 нд Булган аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад сумын ЗДТГ-ын дарга оролцсон. | 100% |
| 17.6 | Цэргийн бүртгэлийг зохион байгуулах, хөтлөх, хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах, гэрээт цэрэг татлагын байранд хүргэхэд шаардагдах тээврийн, хүнсний зардлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцах | 2022 оны цэргийн тоо бүртгэл явуулах ажлыг аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу сумын ЗДТГ-ын дарга, ХЭЗ мэргэжилтэн, багийн Засаг дарга нар хамтран тоо бүртгэлийг хугацаанд нь явуулж дүнг Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабт тушаасан. Тоо бүртгэл явуулах тов хугацааг мэдээллийн самбар болон байгууллагын ажилтны хурал, цахимаар нийт иргэдэд хүргэж, алслагдсан багийн засаг дарга нарыг тээврийн хэрэгслээр хангаж, зарлан мэдээлэх хуудсыг тараасан.<br>2022 оны 1, 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагыг аймгийн Засаг даргын А/126, А/390 тоот захирамж, сумын Засаг даргын А/53, А/130 тоот захирамжийн дагуу иргэнийг хугацаат цэргийн албанд татах ажлыг түргэн шуурхай, чанартай зохион байгууллаа.<br>Цэрэг татлагад хоёрдугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтнийг бүрэн хамруулах зорилгоор багийн Засаг дарга нарыг тээврийн хэрэгсэл, түлш шатахуунаар хангаж давхардсан тоогоор 315 иргэнд зарлан дуудах хуудсыг хүргэлээ. 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар Цагааннуур сумын 18-25 насны нийт 45 залууг сумын Эрүүл мэндийн төвд ковид -19 цар тахлын болон урьдчилсан шинжилгээг өгүүлж Сүхбаатар суманд нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад 50 иргэн Сүхбаатар суманд нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт орсон. Эрүүл мэндээр тэнцсэн залуучууд холбогдох ангиудад цэргийн алба хааж байна.<br>Цэргийн үүрэгтнүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, тэнцсэн цэргүүдийг аймгийн Цэргийн штабт хүлээлгэж өгөхөд шаардагдах | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | тээврийн хэрэгсэл, шатахууны зардал 1749,0 мянган төгрөгийг сумын Засаг даргын нөөцөөс гаргаж зарцуулсан. | |
| 17.7 | Сумын дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөөнд тодотгол хийх, Батлан хамгаалах товчоо, Цугларах байранд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах | Аймгийн ЦШ-тай хамтран сумын дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. Бүрэлдэхүүний сургалт зохион байгуулагдаагүй. | 70% |
| 17.8 | Дайчилгаанд шаардлагатай хүнс, шатах тослох материал, эм ороох боох хэрэгсэл, автомашин болон бусад хэрэгцээт бараа материалаар хангах үүрэг бүхий иргэн, аж ахуй нэгж байгууллага, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах | Дайчилгаанд шаардлагатай хүнсний гэрээг сумын Ноён уулын хишиг ХХК, Тосон уул дэлгүүртэй байгуулсан. Шатах тослох материалын гэрээг сумын НИК петровис ШТС, Шунхлай ШТС-уудтай байгуулсан | 100% |
| 17.9 | Цэргийн албаны тухай, Дайчилгааны тухай хуульд заасны дагуу цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг давтан сургалтад хамруулах, тэдний дайчилгааны командуудад оногдуулан данслах | Цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулагдаагүй | 0% |
| 17.10 | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг сонгон авч гүйцэтгэх үүрэгт нь сурган дадлагажуулах, гамшиг, осол, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй 4 иргэн байгаа бөгөөд 2022 оны хавар тус суманд малын гоц халварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналтын постонд 3 албан хаагч 7-21 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэсэн. Хавар, намрын хуурайшилтын үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд 7 хоног дайчлан ажиллуулсан. 9 дүгээр сард зохион байгуулагдсан цэргийн дүйцүүлэх албан хаагчдын сургалтад 7 хоног хамрагдсан. | 100% |
| 17.11 | Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд мөнгөн төлбөр ногдуулж төлөлтөд хяналт тавьж ажиллах | Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 17 иргэнд багийн Засаг дарга нараар дамжуулан мэдэгдэл өгсөн ба 1 иргэн мөнгөн төлбөрөө төлсөн байна. Мөнгөн төлбөр төлөх 9 иргэнийг бичиг баримтын хамт аймгийн ЦШ-т холбогдох албан тушаалтнуудтай уулзуулж мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоолгосон. | 70% |
| 17.12 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулах | 2022 оны 1 дүгээр ээлжинд татагдсан залуучуудыг сумын эрүүл мэндийн төвд 6 төрлийн шинжилгээнд хамруулж үзлэг оношилгоог хийж бүртгэлжүүлсэн. 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагад татагдсан иргэдийг Сүхбаатар суманд аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан картыг сумын | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ЭМТ-ийн эмч хариуцан авч 1 иргэнийг давтан шинжилгээнд хамруулж эмчилсэн. | |
| 17.13 | Аймгийн засаг даргаас зохион байгуулах " Эрүүл иргэн-Энхийн манаа" арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, иргэдийг хамруулах | Зохион байгуулагдаагүй | 0% |
| 17.14 | Улсын дайчилгааны төлөвлөгөөний дагуу зайлшгүй байх нөөц бүрдүүлэх даалгаваржуулсан аж ахуй нэгжүүдтэй гэрээ хийж, үр дүнг тооцож ажиллах | Улсын дайчилгааны төлөвлөгөөний дагуу 4 аж ахуйн нэгж хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зайлшгүй байх нөөц бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 17.15 | Орон нутгийн цэргийн отряд сумангуудын хүн, техник, зэвсэглэлд тодотгол хийх | Аймгийн Цэргийн штабтай хамтран орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүн, техникийн томилгоожилт, тодотголыг хугацаанд нь хийсэн. | 100% |
| 17.16 | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах болон бие бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах | Зохион байгуулагдаагүй | 0% |
| 17.17 | Батлан хамгаалах бодлогын чиглэлээр гаргасан тушаал, шийдвэр, үүрэг даалгавар, мэдээ, судалгааг тухай бүрд нь хугацаа хоцруулахгүйгээр хэрэгжилтийн тайланг стандарт, шаардлагын дагуу бодит мэдээлэлд үндэслэн гаргаж ирүүлэх | Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас ирүүлсэн МУ-ын Засгийн газрын тогтоол 1, аймгийн Засаг даргын захирамж 4, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын даргын тушаал 1, цэргийн штабаас ирүүлсэн 7 албан бичгийн хүрээнд цэргийн тоо бүртгэл, 2022 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлага, сумын дайчилгааны бэлтгэл нөөцийн гэрээ хийх, нууцын зэрэглэл бүхий баримт бичиг хураалгах, хугацаатай тайлан мэдээ судалгаа явуулах зэргээр захирамж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь явуулж ажилласан. | 100% |
| 17.18 | Цэргийн бүртгэлд байгаа эрчүүдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж бүртгэл хөтлөх | Цэргийн насны бүртгэлд байгаа иргэн шилжилт хөдөлгөөн хийлгэх хүсэлт гаргахад аймгийн Цэргийн штабт бүртгүүлж хасалт хийлгэх зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн хавар намрын цэрэг татлагын үеэр шилжилт хөдөлгөөн хийхгүй байх талаар улсын бүртгэгчтэй хамтран ажилласан. Цэргээс халагдсан иргэдийн бүртгэлийг багийн Засаг дарга нараар дамжуулан шинэчлэн бүртгэж 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн шилжин ирсэн болон шилжсэн иргэдийн бүртгэлийг тухай бүр хийн бүртгэлжүүлж байна. | 100% |
| 17.19 | Гэрээний хэрэгжилтийн тайланг хагас жилээр 05 дугаар сарын 15-ны дотор, бүтэн жилээр 12 дугаар сарын 01-ний дотор үр дүнг тооцон ирүүлэх. | Гэрээний хэрэгжилтийг бүтэн жилээр гаргаж хугацаанд нь явуулсан. | 100% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| 1 | Ажил арга хэмжээ | Зорилтын тоо | Биелэлт хувиар | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАНГАХ, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | | 19 | 14 | 2 | | | 3 | 81% |

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**
**ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| Ажил арга хэмжээ | | Зорилт ын тоо | 2022 он /хувь | | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | Төрийн захиргаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажил, арга хэмжээ | 15 | 15 | | | | | 100% |
| 2 | Хууль, эрх зүйн салбарын ажил, арга хэмжээ | 16 | 11 | 5 | | | | 91% |
| 3 | Хөдөө аж ахуйн салбарын ажил арга хэмжээ | 21 | 15 | 2 | 1 | 3 | | 85% |
| 4 | Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн салбарын ажил, арга хэмжээ | 16 | 11 | 2 | 2 | | 1 | 84% |
| 5 | Аялал жуулчлалын салбарын ажил, арга хэмжээ | | | | | | | |
| 6 | Худалдаа, үйлчилгээ, жижиг, дунд үйлвэрлэл, өрхийн аж ахуйг дэмжих ажил, арга хэмжээ | 13 | 4 | 4 | 3 | 1 | 1 | 67% |
| 7 | Хөрөнгө оруулалтын ажил, арга хэмжээ | 9 | 9 | | | | | 100% |
| 8 | Хот төлөвлөлт, дэд бүтцийн салбарын ажил, арга хэмжээ | 9 | 3 | 2 | 2 | 2 | | 70% |
| 9 | Боловсролын салбарын ажил, арга хэмжээ | 17 | 13 | 3 | 1 | | | 92% |
| 10 | Биеийн тамир, спортын салбарын ажил, арга хэмжээ | 6 | 5 | | | 1 | | 89% |
| 11 | Эрүүл мэндийн салбарын ажил, арга хэмжээ | 41 | 41 | | | | | 100% |
| 12 | Соёл урлагийн салбарын ажил, арга хэмжээ | 14 | 8 | 4 | 1 | | 1 | 75% |
| 13 | Хүн ам зүйн салбарын ажил арга хэмжээ | 11 | 7 | 1 | 1 | 1 | 1 | 78% |
| 14 | Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын салбарын ажил, арга хэмжээ | 14 | 10 | 1 | 2 | 1 | | 86% |
| 15 | Төсөв санхүүгийн ажил, арга хэмжээ | 10 | 10 | | | | | 100% |
| 16 | Статистикийн салбарын ажил, арга хэмжээ | 7 | 7 | | | | | 100% |
| 17 | Үндэсний аюулгүй байдлын хангах, батлан хамгаалах салбарын ажил, арга хэмжээ | 19 | 14 | 2 | | | 3 | 81% |
| **Нийт** | | **238** | **183** | **26** | **13** | **9** | **7** | **89%** |

НЭГТГЭЛ ХИЙСЭН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АЛТАНЗОРИГ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА Ц.БАЯНБААТАР